

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
12 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-50
	1. Эрүүл мэндийн яамны цахим шилжилтийн үйл ажиллагаа, Дэлхийн банкны санхүүжилттэй “Цахим эрүүл мэнд” төслийн хэрэгжилтийн талаарх холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох	4-31
	2. Нүүрсийг цахимаар арилжих бэлтгэл ажлын талаар холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох	31-50

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы  
Инновац, цахим бодлогын байнгын хорооны 12 дугаар сарын 20-ны өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Э.Батшугар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 38 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Ганибал;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Ундрам;  
Тасалсан: Ц.Сэргэлэн.

**Нэг. Эрүүл мэндийн яамны цахим шилжилтийн үйл ажиллагаа, Дэлхийн банкны санхүүжилттэй “Цахим эрүүл мэнд” төслийн хэрэгжилтийн талаарх холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Сарансүх, Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Буянтогтох, “Цахим эрүүл мэнд” төслийн зохицуулагч Б.Амарсанаа, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Taihan Cable & Solution компанийн төслийн дотоодын менежер Ө.Эсболд, “Метронетворкс” ХХК-ийн ахлах инженер Э.Халиунаа, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дарга Д.Нарантуяа, Үндэсний Дата Төв Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал М.Баттулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх П.Батбаатар, референт П.Болорцэцэг нар байлцав.

Эрүүл мэндийн яамны цахим шилжилтийн үйл ажиллагаа, Дэлхийн банкны санхүүжилттэй “Цахим эрүүл мэнд” төслийн хэрэгжилтийн талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх, Taihan Cable & Solution компанийн төслийн дотоодын менежер Ө.Эсболд, “Метронетворкс” ХХК-ийн ахлах инженер Э.Халиунаа нар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ц.Идэрбат нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Буянтогтох, “Цахим эрүүл мэнд” төслийн зохицуулагч Б.Амарсанаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Эрүүл мэндийн яамны цахим шилжилтийн үйл ажиллагаа, Дэлхийн банкны санхүүжилттэй “Цахим эрүүл мэнд” төслийн хэрэгжилтийн талаарх холбогдох байгууллагуудын мэдээллийг сонсов.

*Уг асуудлыг 13 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Нүүрсийг цахимаар арилжих бэлтгэл ажлын талаар холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Батнайрамдал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, мөн хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Нэгдсэн удирдлага стратегийн хэлтсийн дарга Б.Цэвэгжав, мөн компанийн Маркетинг, борлуулалтын хэлтсийн дарга Г.Адъяа, “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” улсын үйлдвэрийн газрын захирал Т.Батбилэг, Монголын Хөрөнгийн биржийн Бизнес хөгжлийн газрын захирал Т.Хаш-Эрдэнэ, Монголын хөрөнгийн биржийн хуульч Г.Тэмүүжин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх П.Батбаатар, референт П.Болорцэцэг нар байлцав.

Нүүрсийг цахимаар арилжих бэлтгэл ажлын талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Батнайрамдал нар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Э.Батшугар нарын тавьсан асуултад Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Батнайрамдал, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Монголын Хөрөнгийн биржийн Бизнес хөгжлийн газрын захирал Т.Хаш-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Э.Батшугар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Нүүрсийг цахимаар арилжих бэлтгэл ажлын талаар холбогдох байгууллагуудын мэдээллийг сонсов.

*Уг асуудлыг 14 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 05 минут үргэлжилж, 11 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 14 цаг 43 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Э.БАТШУГАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
12 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ**

**Э.Батшугар:** Байнгын хорооны эрхэм гишүүд энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн тул Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Э.Батшугар 28 дугаар тойрог, Э.Бат-Амгалан 23 дугаар тойрог, Х.Ганхуяг 26 дугаар тойрог, Ц.Идэрбат 18 дугаар тойрог, Б.Саранчимэг 22 дугаар тойрог, Ж.Чинбүрэн 23 дугаар тойрог.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хоёр асуудал байгаа. Эхнийх нь Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2021 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилт, Эрүүл мэндийн яамны цахим шилжилтийн үйл ажиллагаа, Дэлхийн банкны санхүүжилттэй Цахим эрүүл мэнд төслийн хэрэгжилтийн талаар холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох.

Хоёрдугаар асуудал, Нүүрсийг цахимаар арилжих бэлтгэл ажлын талаарх холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

***Нэг. Эрүүл мэндийн яамны цахим шилжилтийн үйл ажиллагаа, Дэлхийн банкны санхүүжилттэй “Цахим эрүүл мэнд” төслийн хэрэгжилтийн талаарх холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох***

Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2021 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилт, Эрүүл мэндийн яамны цахим шилжилтийн үйл ажиллагаа, Дэлхийн банкны санхүүжилттэй Цахим эрүүл мэнд төслийн хэрэгжилтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболд танилцуулна.

3 дугаар микрофоныг нээе.

**С.Энхболд:** Эрхэм хүндэт Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга болон эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Даргаас бас нэг хүсэлт байна. Би мэдээллээ товчхон хийгээд хамгийн гол нь яг бодит орчинд энэ цахим эрүүл мэндийн төсөл маань ямархуу хэрэгжилтийн түвшинд явж байгааг бас бид энэ бодит орчинд нь харуулъя гэж зорьсон байгаа. Энэ дээр илүү гол мэдээллээ өгөөд явчихъя гэж бодож байна.

**Э.Батшугар:** Тэгье тэгье. Бодитой символичной хийх гээд байгаа юм байна шүү дээ. Ассимиляц. Тийм ээ.

**С.Энхболд:** Тийм. Эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологийг хөгжүүлэх хүрээнд мэдээлэл солилцооны нэгдсэн сүлжээ байгуулах, салбарын энтерпрайз архитектурыг үндэсний интерпрайз архитектурт нийцүүлэх олон улсын стандартыг өөрийн орны онцлогт уялдуулан нутагшуулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд бие даасан программ хангамж, системийг үе шаттай нэвтрүүлж байна.

Тус салбарт мэдээллийн чиглэлээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Экспорт, импорт банкны санхүүжилттэй **e-Health** төслийг 2012 онд хэрэгжүүлж лавлагаа шатлалын 48 эмнэлгийн эрүүл мэндийн байгууллагад сервер, компьютер, эмнэлгийн программ хангамж нийлүүлэгдсэн.

Мөн Дэлхийн банкны дэмжлэгтэй “**Цахим эрүүл мэнд**” төслийг 2016 оноос тус тус хэрэгжүүлж эрүүл мэндийн өгөгдөл солилцооны нэгдсэн платформ өгөгдлийн тайлбар, толь стандартыг боловсруулсан.

Түүнчлэн Бүгд Найрамдах Солонгос Улсын Эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагааны сангийн санхүүжилтээр хэрэгжсэн “**Үндэсний оношилгоо, эмчилгээний төв**” төслийн хүрээнд 2012-2019 онд телемедициний нэгдсэн сүлжээ байгуулж, Эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээний мэдээллийн цахим системийг 2018 оноос нэвтрүүлсэн.

Эрүүл мэндийн салбарт нийт 50 гаруй программ хангамжийг өдөр тутмын үйлчилгээндээ хэрэглэж байгаа бөгөөд мэдээллийн системийн үйл ажиллагаа, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, зөвлөхүүдээр гүйцэтгүүлж байна.

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр эрүүл мэндийн мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх замаар эмнэлэг хооронд мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэх, эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх үйл ажиллагааг цахим хэлбэрт оруулах, оношилгоо, эмчилгээний дүрс архивлан хадгалах, солилцох системийг боловсруулж хэрэгжүүлэх олон улсын нээлттэй тендерээр шалгаруулж хэрэгжиж дууссан. Гэрээний дагуу Улсын Нэгдүгээр төв эмнэлэг, Улсын Гуравдугаар төв

эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв /ГССҮТ/, Увс, Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлгүүд амжилттай хэрэгжсэн.

Эрүүл мэндийн өгөгдөл солилцооны нэгдсэн платформ хөгжүүлж нэвтрүүлэх үйл ажиллагааг эхлүүлсэн. Тус платформ нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч бүхий л байгууллагууд хооронд өвчтөн, үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн байдал, өвчтөний түүх, эрүүл мэндийн байгууллагаас өмнө авч байсан эмчилгээ, үйлчилгээний тухай үнэн зөв мэдээллийг цаг алдалгүй солилцон оношилгоо, эмчилгээний шийдвэр гаргалт ашиглалтад ашиглах замаар эрүүл мэндийн үйлчилгээний үр ашиг, чанарыг сайжруулах, эмнэлэг, эмчилгээний алдаа гаргахаас сэргийлэх, өвчтөн, үйлчлүүлэгчдийн зардал, чирэгдлийг багасгах зорилготой платформ юм.

Төслийн хүрээнд Монгол Улсын нийт анхан шатны эмнэлгүүдэд **e-hospital.mn** системийг хэрэгжүүлэх, цаашид бодит цагаар эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын системтэй холбож анхан шатны 535 эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлээд байна.

Цахим хэлбэрээр үзүүлж буй төрийн үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем, **e-mongolia** цонхонд нэгтгэх ажлын хүрээнд тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлийг нэвтрүүлсэн.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад ашиглаж буй программ хангамжуудын бодит хугацаанд өгөгдөл солилцох хөгжүүлэлтийг ажил бүрэн дуусаж, эрүүл мэндийн байгууллагуудад санхүүжилтээ бодит хугацаанд нь цахимаар нэхэмжлэх боломжийг бүрдүүлсэн.

E-mongolia системд эмч, эмнэлгээс иргэдэд олгодог нийт 17 төрлийн лавлагаа, үйлчилгээ, тодорхойлолтыг олгож эхэлсэн.

Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, цахим уриалга, урилга, мэдэгдэл, түүнчлэн илрүүлэг, үзлэгийн хариуг **e-mongolia** системээр дамжуулан иргэдэд хүргэн ажиллаж байна.

2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр А/509, А/60 Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан.

Тус ажлын хэсгээр эрүүл мэндийн салбарын цахим шилжилттэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Эрүүл мэндийн тухай хуулийн 8.4 дэх хэсэгт заасны дагуу эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн сангийн өгөгдөл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглах журмын төслийг хамтран боловсруулан ажиллаж байна. Ингээд мэдээлэл хийж дууссан.

“Цахим эрүүл мэнд” төслийн гүйцэтгэгч компанийн менежер Ө.Эсболд яг энэ бодит орчинд энэ программ хангамж ямархуу түвшинд явааг танилцуулна.

**Э.Батшугар:** 4 номерын микрофоныг нээе.

**Ө.Эсболд:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг айлтгая. Намайг Ө.Эсболд гэдэг. Энэ “Цахим эрүүл мэнд” төслийн эрүүл мэндийн өгөгдөл солилцооны платформын Монгол дахь менежер “Тайхан электрик” болон “Бит компьютер”-ыг төлөөлөөд энд сууж байна.

Тэгэхээр би яг бодит орчинд юмаа үзүүлэхээсээ өмнө бид юу юу хийчихсэн юм. Яг ямар байдалтай байгаа юм гэдэг талаар нь товч мэдээллийг маш түргэн өгье.

Тэгэхээр гүйцэтгэгч компаниар “Тайхан электрик” болон “Бит компьютер” гээд Солонгосын хоёр компаниудын түншлэл орсон. Туслан гүйцэтгэгчээр Рак системс гээд компани ажилласан “**Аксис системс**” гээд компани ажилласан.

“Аксис системс” компани гол нь мэдээллийн аюулгүй байдлын үүднээс монгол хүний дататай харьцахгүй байх үүднээс Солонгос компанийн ажилчдыг ерөөсөө ажиллуулаагүй. Зөвхөн туслан гүйцэтгэгч Монгол компаниудыг ажиллуулсан. Гэрээ албан ёсоор 18 сарын хугацаатай. 2021 оны 9 сард албан ёсоор эхэлсэн. Ерөнхийдөө 2023 оны 4 сард дуусна гэсэн ийм төлөвлөгөөтэй байж байгаа.

Төлөвлөгөөний гол хэдэн зорилт нь бид олон улсын стандартыг нэвтрүүлэх буюу **FHIR**<sup>[Fast Health Interoperability Resource<sup>1</sup>]</sup> гээд өгөгдөл солилцох стандартыг нэвтрүүлэх.

Хоёрт нь, **electronic health record**<sup>2</sup> /HER/-ыг бий болгох.

Гуравт нь, өвчтөн төвтэй буюу өвчтөний порт буюу “цахим карт”-ыг бий болгох.

Тэгээд бусад эмнэлгүүдтэй эрүүл мэндийн өгөгдөл солилцооны платформоор хооронд нь мэдээллийг нь дамжуулах.

Хамгийн сүүлийнх нь анхан шатны эмнэлгүүдийг бүгдийг нь нэг ижил стандарттай эмнэлгийн системээр хангах гэсэн ийм гол зорилтуудтай эхэлсэн байж байгаа.

Бид **electronic health record**-ыг яагаад бий болгох гээд байгаа юм гэхээр өвчний “цахим карт” буюу өөрөөр хэлбэл систем орж эхэлснээс хойш иргэний хувьд хүүхэд төрөх юм бол төрснөөс нь нас барах хүртэлх бүх мэдээллийг, өөрөөр

<sup>1</sup> Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээллийг систем хооронд дамжуулах стандарт.

<sup>2</sup> Өвчтөний эрүүл мэндийн түүхийн цахим бүртгэл.

хэлбэл цаасан мэдээлэл биш цахим өгөгдлийг нэг доор цуглуулж иргэнд нь харуулах зориулалттайгаар хийж байгаа.

Үүнийгээ бид **electronic health record** гэж нэрлээд байгаа. Энэ дотор нь юу байх юм гэхээр тухайн өвчтөний шинж тэмдэг, цахим бүртгэл, цусны бүлэг, эрүүл мэндийн түүх, эмэгтэй хүн бол жирэмслэлт, үр оношилгоо, дархлаажуулалт гээд ингээд байж болох бүх мэдээллүүдийг ерөнхийдөө хамруулж байгаа.

“**Өвчтөний портал**” маань ерөнхийдөө бодитоор би харуулна. Ерөнхийдөө загвар маань ийм байдалтай харагдаж байгаа.

Тэгэхээр ер нь “**өвчтөний портал**” руу цуглуулахын тулд энэ мэдээлэл нь хаанаас ирж байгаа юм гэхээр ямар эмнэлэгт үзүүлсэн байхаас үл хамаараад, өөрөөр хэлбэл манай эрүүл мэндийн өгөгдөл солилцооны платформд холбогдсон эмнэлэг л байх юм бол тухайн эмнэлгийн тухайн үзүүлсэн өвчний бүх түүхүүд энэ “**өвчтөний портал**” буюу “**цахим карт**” гэж нэрлээд байгаа. Ийшээгээ ирэх юм.

Бид ерөнхийдөө **FHIR** гээд олон улсын стандартаа юу гэж нэрлээд байгаа юм гэхээр маш олон янзын эмнэлгийн системүүд байгаа. Манайд арван хэдэн эмнэлгийн систем үйлдвэрлэгч компаниуд байдаг. Бүгд өөр өөрийн гэсэн стандартаар хийчихсэн.

Тийм учраас эд нарыг нэг стандартаар нэг хэлээр ойлгуулах зайлшгүй шаардлага гарсан.

Бидний хувьд гарсан хамгийн том хүндрэл гэвэл манай энэ төслийг эхлэхийн өмнө бэлтгэл шатыг хангах ёстой байсан **CHORUS** гээд компани ажлаа хийгээгүй. Ажлаа хийгээгүйгээс болж бид нар мэдээллийн толь бичиг, өөрөөр хэлбэл эрүүл мэндийн толь бичиг гэдэг юмыг авч чадаагүй.

Үүнийг авч чадаагүйгээс болж бид нар өөрсдөө боловсруулах шаардлагатай болсон. Ингээд яамнаас тусламж аваад бид нар нэг ёсондоо лабораторийн салбар зөвлөл, эмнэлгийн салбар зөвлөлүүдтэй хамтарч байгаад нэг стандартад оруулсан.

Ерөнхийдөө олон улсын тэр **FHIR** стандартад оруулахад ашиглаж байгаа бид нарын кодууд буюу **LOINC**<sup>3</sup><sub>[Logical Observation Identifier Names and Codes]</sub> гээд лабораторийн код, **SNOMED CT**<sup>4</sup><sub>[Systematized Nomenclature of Medicine - Clinical Terms]</sub> гээд эмнэлгийн эмнэл зүйн

---

<sup>3</sup> Логик ажиглалтын танигч нэр, код (LOINC) нь эмнэлгийн лабораторийн ажиглалтыг тодорхойлох, тайлагнах стандартчиллагдсан түгээмэл аргыг хөнгөвчлөх зорилгоор тусгайлан бүтээгдсэн мэдээллийн сан, үгсийн санг кодлох систем.

<sup>4</sup> Эмнэлзүйн нэр томъёо (SNOMED CT) нь эмч нар болон бусад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн эмнэлзүйн эрүүл мэндийн мэдээллийг цахимаар солилцоход ашигладаг эмнэлзүйн нэр томъёоны стандартчилсан олон хэл дээрх толь бичиг.



шинж тэмдгийн кодуудыг ингээд бүгдийг нь стандартад оруулах гэж маш их цаг алдсан.

Энэ нь манай ажлын хүрээний ажил байгаагүй. Гэхдээ бид энэ дээр яамтайгаа хамтраад ингээд үүнийг боловсруулсан байж байгаа.

Ерөнхийдөө **HIEP** /Health Information Exchange Platform/-ийн зорилго юу байгаад байгаа юм гэхээр бид улсын эмнэлгүүдийг холбох, Үндэсний дата төвийг холбож байгаа, Нийгмийн даатгалын ерөнхий газартай ажиллаж байгаа.

Гуравдагч талууд буюу гуравдагч эмнэлгийн систем, мөн үйлдвэрлэгчид, янз бүрийн эмнэлгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа программ хангамжууд.

Дээр нь хувийн эмнэлгүүд. Дээр нь Монгол Улсын эрүүл мэндийн салбарын статистик мэдээлэл боловсруулж байгаа **“H-info”** программтай хамтран ажиллах.

Дээр нь мөн **“Цахим эрүүл мэнд”** төслийн хүрээнд хэрэгжсэн факс төсөлтэй хамтран ажиллах гэсэн ерөнхийдөө ийм зориулалттайгаар хийгдсэн.

Цаад талдаа бид яг **e-mongolia**-тай бас нягт ажиллаж байгаа. Жишээ нь, **e-mongolia**-гаар иргэнийхээ баталгаажуулалтыг өвчний портал руу орохдоо хийж байгаа. **E-mongolia**-гаар дамжуулаад **“Хур”** ашиглаад байгууллага болон иргэний мэдээллийг дандаа **“Хур”**-аас татаж ашиглаж байгаа. Өөрөөр хэлбэл ямар нэгэн байдлаар гараас мэдээлэл ордоггүй байдлаар хийсэн.

5 сарын 01-нд систем маань эхэлсэн. 5 сарын 01-нд систем маань бий болоод эхэлсэнтэй холбоотойгоор эрт илрүүлгийн систем манай одоо, өөрөөр хэлбэл **HIEP** гээд платформын нэг хэсгийг ашиглаад үйл ажиллагаагаа явуулаад эхэлсэн.

Энэ үйл ажиллагаа эхэлсэнтэй холбоотойгоор улсын лавлагаа шатлалын **“e-Health”** эмнэлгүүд бүгд холбогдсон. Анхан шатны эмнэлгүүд буюу 539 анхан шатны эмнэлэг холбогдсон. **“E-Clinic”** хувийн хэвшлийн 33 эмнэлэг холбогдсон. **“MedSoft”** гээд хувийн хэвшил болон төмөр зам, төрийн тусгай холбогдсон 3 эмнэлэг холбогдсон. **“Karte”** гээд мөн адилхан улсын болон хувийн хэвшилд явж байгаа 12 эмнэлэг холбогдсон. Дээр нь Эрүүл мэндийн даатгалын газар холбогдсон. 5 сарын 01-нээс эхлээд үйл ажиллагаа буюу өөрөөр хэлбэл эрүүл мэндийн өгөгдөл солилцооны платформоор датагаа солилцоод явж байгаа.

Үүнтэй давхар бид өөр ямар газруудтай мэдээлэл солилцож байгаа вэ гэхээр **e-mongolia**-тайгаа бид тэр цаг захиалга, эсвэл бусад нөгөө нэвтрэх, дангаар нэвтрэх, иргэнээ баталгаажуулах тал дээр ажиллаж байгаа.

**E-mongolia** дээр бид анхан шатны эмнэлгийн цаг захиалах оруулах үйлчилгээг өгчхөөд нэлээн хэдэн сар болж байна. **E-mongolia** хүний нөөцийн дутуугаас хөгжүүлэлт нь болохгүй байна гээд хүлээлттэй байж байгаа.

**LICEMED**<sup>[www.licemed.mohs.mn]</sup> буюу эмийн программтай бид зуун хувь хамтарч ажиллаж байгаа. Өөрөөр хэлбэл Монгол Улсын зөвшөөрөгдсөн бүх эмийг **НIEP** системээр дамжуулж ажиллахаар болсон. “**H-info**”-тойгоо бид бүх мэдээллээ солилцож байгаа.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай одоогоор яаж явж байгаа вэ гэхээр эрт илрүүлэгтэй хамааралтай бүх төлбөр тооцоо зөвхөн эрүүл мэндийн өгөгдөл солилцооны платформоор дамжиж очиж байгаа. Түүнээс биш эмнэлэг эмнэлгээс биш гэсэн үг.

Тэгэхээр бусад хийсэн нэмэлт ажлууд, бид нарын гэрээнд байхгүй нэмэлт ажлууд юу байсан гэхээр бид анхан шатны эмнэлгийн системийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 04/05 дугаар тогтоол гарсантай холбогдуулаад 539 анхан шатны эмнэлгүүдийг Даатгалын ерөнхий газартай шууд холбож, одоо төлбөр тооцоо дандаа цахимаар явдаг болсон.

Мөн анхан шатны эмнэлгийн системээс халдварт бус болон хэвтэн эмчлүүлэгчийн мэдээллийг “**H-Info**” программ руу шууд цахимаар илгээдэг болчихсон.

Дээр нь бид эрүүл мэндийн үйлчилгээ болон сая хийсэн лабораторийн нэршлийг нэг стандартад оруулан **SNOMED CT** буюу 360 мянга орчим өгөгдлийг орчуулаад үүнээсээ бид одоогоор 10-аад мянгыг нь ашиглаж байгаа.

**LOINC** буюу олон улсын лабораторийн, голдуу лабораторид ашигладаг олон улсын кодыг ихэнх байгууллагууд нэвтрүүлээд оруулчихсан.

Тэгэхээр би энэ хажуу талд нь нэг зураг тавьчихсан байгаа. Жишээ нь, яагаад үүнийг ингээд стандартжуулах шаардлага гарсан гэхээр жишээ нь энэ амилаза гээд л тэгэхэд манай эмнэлгүүд ингээд янз бүрээр нэрлэчихсэн байдаг. **Амилаза**<sup>5</sup> гээд л ардаа “цус” гээд биччихсэн. Амилаза гээд ташуу зураас аваад “цус” гээд биччихсэн.

Тэгэхээр би жишээ нь нэг эмнэлгээс амилаза гэдэг мэдээллийг дамжуулахад ижил форматтай байхгүй бол нөгөө талын эмнэлэг нь ойлгохгүй болчихоод байсан.

Тийм учраас эдгээрийг нэг стандартад оруулж, нэг мэдээлэлтэй болгох ийм шаардлага гарсан учраас бид үүнийг хийсэн.

Анхан шатны эмнэлгийн системүүд 2022 оны 02 сарын 01-нээс эхэлсэн. Эрүүл мэндийн даатгалтай тэр Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн

---

<sup>5</sup> Амилаза шинжилгээ нь цус болон шээсэн дэх амилазагийн хэмжээг хэмждэг. Амилаза нь хоол боловсруулахад тусалдаг фермент буюу тусгай уураг.

04/05 дугаар тогтоолын холболтыг 4 сард дуусгасан. Одоогийн байдлаар 539 анхан шатны эмнэлэг холбогдчихсон. Үндэсний дата төв дээр үндсэндээ систем маань байршиж байгаа. Ерөнхий харагдах байдал нь иймэрхүү байж байгаа.

Тэгэхээр төсөл ерөнхийдөө бид саяын тэр стандартыг хүлээсэнтэй холбоотойгоор нэлээдгүй цагийг алдсан. Түүнээс систем бол бэлэн байсан.

Тэгэхээр одоо ерөнхийдөө бид сая Лабораторийн салбар зөвлөл, Эрүүл мэндийн салбар зөвлөлтэй ажиллаад ерөнхийдөө стандартуудыг сая 11 сарын дундуур дуусгасан. Үүнтэй холбоотойгоор систем рүүгээ оруулаад ерөнхийдөө бэлэн байдал хангагдсан ийм байж байгаа.

Бид нарт тулгарсан бэрхшээл. Бид нар 2021 оны 7 сараас эхлэн техник, тоног төхөөрөмжийг Дэлхийн банкнаас худалдаж авахыг хүссэн хүсэлтийг хэд хэдэн удаа тавьсан боловч бид нарт техник хангамж авч өгөөгүй.

Техник авч өгөөгүйгээс болж бид ямар байдалд орсон гэхээр системүүдээ суурилуулах тоног төхөөрөмжийн дутагдалд орсон. Энэхүү дутагдлаас болж бид яамтайгаа ярилцаж байгаад жишээ нь **e-hospital** буюу 539 анхан шатны эмнэлэг явж байгаа системийг Хоёрдугаар эмнэлгийн серверүүдийн зарим хэсэг дээр нь суурилуулсан. Өөрөөр хэлбэл нэг ёсондоо хүний сервер дээр суулгаж эхэлсэн гэсэн үг.

**НIEP** систем буюу “**эрүүл мэндийн өгөгдөл солилцооны платформ**”-ыг 05 сарын 01-нд эхлүүлэхтэй холбоотойгоор бид Сонгинохайрхан дүүргийн эмнэлэгт ашиглагдаж байсан 7 серверийг түр зууртаа аваад дата төв дээр байршуулаад одоо түүн дээр явж байгаа гэсэн үг.

Тэгэхээр систем бүрэн, хэвийн, найдвартай ажиллахын тулд бид нарт 22 сервер шаардлагатай байсан. Гэтэл энэхүү сервер, тоног төхөөрөмж худалдаж авч өгөөгүйгээс хамааралтайгаар бид яг өнөөдөр техник, тоног төхөөрөмжийн хүндрэлд байгаа.

Өнөөдөр бид бүх модулаа нэвтрүүлээд бэлэн байгаа ч гэсэн ашиглуулаад эхэлчих юм бол магадгүй гэв гэнэт систем дээр ачаалал үүсээд техник маань гацах магадлалтай байгаа гэдгийг хэлмээр байгаа юм.

Мөн хэлсэн. Сая тэр системийг нэвтрүүлэх шаардлагатай эрүүл мэндийн мэдээллийн технологийн тайлбар толь бичгийг тэр Шведийн CHORUS гээд компани хийх байсан боловч хийж өгөөгүй учраас бид энэ өгөдлийн тайлбар толь бичгийг яамтайгаа хамтраад өөрсдөө нэмэлтээр хийсэн.

Гурав дахь асуудал, мэдээж санхүүгийн дутагдал. Бид санхүүгээ хуваарийн дагуу ерөөсөө авч чадахгүй байгаа. Одоогийн байдлаар ердөө 20-хон хувийн төлбөр авсан. Гэхдээ ажил маань бидний хувьд бараг 90 хувь, 100 хувь болсон гэж үзэж байгаа.

Дээр нь бид ганцаараа энэ системийг хөгжүүлээгүй. Бид нэг ёсондоо дэд бүтэц буюу эрүүл мэндийн салбарын арын системийг хийж байгаа.

Тэгэхээр манай гол харилцагч талууд буюу энэ 10-аад эмнэлгийн систем хөгжүүлэгч байгууллагууд маань бид нартай нягт хамтран ажиллах ёстой.

Тэгэхээр эдгээр эмнэлгийн систем хөгжүүлэгч байгууллагуудын маань хөгжүүлэлтийн сааталтайгаас хамааралтай бас саатлууд үүсэж байгаа. Ингээд ерөнхийдөө миний танилцуулга болсон. Тэгэхээр би одоо Та бүхэнд ер нь системээ үзүүлэхэд бэлэн болсон.

Тэгэхээр одоогоор бид яг бодит орчинд бэлдчихсэн. Өөрөөр хэлбэл яг үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгэхээр эндээс хоёр янзын эмнэлгийг сонгосон байгаа. Нэг нь, **“Метронэтворкс”** компанийн хэрэгжүүлсэн лавлагаа шатлалын эмнэлгүүдээс Дундговь аймгийн нэгдсэн эмнэлгийг сонгосон байгаа.

Дундговь аймгийн нэгдсэн эмнэлэг рүү Э.Халиун гээд **“Метронэтворкс”** компанийн инженер ирчихсэн датагаа үзүүлнэ.

Миний зүгээс болохоор **“Ангирмаа”** гээд Баянгол дүүргийн нэг өрхийн эмнэлгийг сонгосон. Ховд аймгийн Мянгад сумын нэг эрүүл мэндийн төвийг сонгосон. Улсын Хоёрдугаар эмнэлгийг сонгосон. Тэгээд өвчтөний картыг та бүхэнд үзүүлнэ.

Ерөнхийдөө энэ бол **“Ангирмаа”** гээд эмнэлэг рүү би ингээд орчихсон байж байгаа.

Тэгэхээр эмнэлгийн систем маань ерөнхийдөө ингээд өвчтөн үзүүлсэн бол тухайн үзүүлсэн өвчтөний мэдээллүүд үүснэ. Энэ дээр би өөрийгөө сонгосон. Яагаад гэвэл эрүүл мэндийн өгөгдөл бид ямар нэгэн хүний мэдээллийг зөвшөөрөлгүйгээр харах боломжгүй учраас би өөрийгөө сонгосон.

Бид өгөгдөл солилцох гээд байгаа. Өгөгдөл солилцохдоо бид энэ **“13В”** гэдэг маягыг яам боловсруулаад бид энэ дагуу хийж байгаа. **“13В”** маягтай гаргахтай холбоотойгоор одоо бид яамнаас юу хүлээж байгаа вэ гэхээр энэ **“13В”** маягыг зохицуулах журмыг хүлээж байгаа. Өөрөөр хэлбэл **“13В”** маягтаар хүлээж авсан эмнэлэг нь татгалзах юм бол ямар нөхцөлд татгалзах юм. Хариу өгөх юм бол хэд хоногийн дотор хариу өгөх юм. Ямар журмаар явах юм гэдэг журмыг хүлээж байгаа.

Тэгэхээр энэ журам хүлээгдсэнтэй холбоотойгоор шууд. Одоо яг энэ **“Ангирмаа”** гээд эмнэлгийн эмч орчихсон. Өөрөөр хэлбэл би өөрийгөө эмч болгоод бэлдээд орчихсон байгаа гэсэн үг.

Одоо ингээд би “13В”-гээр нөгөө өвчтөнөө илгээх гэж байгаа юм. Энэ маягт яамнаас боловсруулж өгсөн маягт. Жишээ нь, одоо би явуулах гэж байгаа эмнэлгээ сонгоно. Би одоо жишээ нь Мянгад сум руу явуулъя. Ховд аймгийн Мянгад сум руу. Би онош баталгаажуулахаар явуулна. Биеэр очиж болно. Эсвэл сорьц илгээж болно.

Хэрвээ сорьц илгээх юм бол би эд нарыг бөглөх ёстой. Өөрөөр хэлбэл ямар сорьц илгээж байгаа юм. Хатуу, шингэн юм уу, түрхэц юм уу, цэрнээс юм уу. Ингээд сорьцын дугаар. Тэгээд энэ сорьцыг хэзээ авсан он, сар. Сорьцыг авсан ажилтан. Одоо би хэн гээд нэг биччихье. Тийм ээ. Саран гээд ч юм уу. Тэгээд илгээсэн оноо өнөөдөр ч гэдэг юм уу.

Ингээд явуулахаасаа өмнө бид нар юу яах ёстой вэ гэхээр тухайн иргэн дээр байгаа хийгдсэн эрүүл мэндийн үйлчилгээнүүдийг давхар явуулж байгаа. Одоо жишээ нь над дээр бол жишээ нь энэ цусны дэлгэрэнгүй, цээжний дэлгэрэнгүй, алад, төмөр, түргэн тусламж, уураг гээд ийм шинжилгээнүүд хийчихсэн байж байгаа. Дотор нь ямар датанууд байгаа вэ гэдгийг ингээд ороод харчаж болно. Жишээ нь, ингээд нэг нэгээр нь ороод харчаж болно.

Би тэгэхээр энэ 4-ийг жишээ нь явуулъя. Тэгэхээр энэ явуулах сонголт нь уг нь бол иргэнд байх ёстой. Өөрөөр хэлбэл эмч бүгдийг нь явуулах байсан ч гэсэн иргэн эндээсээ 4-ийг нь явуулъя, 3-ыг нь явлаа ч гэдэг юм уу. Магадгүй эмзэг мэдээллүүд байх юм бол явуулахгүй байх боломжтой. Тийм учраас ийм сонголттой байдлаар хийж өгсөн.

Тэгэхээр аль алиныг явуулах юм бэ гэдгээ ингэж сонгож байгаад. Би жишээ нь энэ 3-ыг явуулъя. Өөрөөр хэлбэл Ховд аймгийн Мянгад сум руу илгээнэ гэсэн үг. Ингээд сонгочихсон бол илгээх товчийг дараад илгээнэ. Ингээд амжилттай илгээгдчихсэн.

Би илгээсэн юмаа яаж харж байгаа вэ гэхээр ерөнхийдөө тухайн эмнэлэг дээр энэ “13В” маягтаар ирсэн мэдээллүүд ингээд байж байгаа. Энд бид нар ингээд янз бүрийн байдлаар мэдээлэл солилцож байсан мэдээллүүд байж байгаа. Жишээ нь, одоо энд ирсэн мэдээллүүд. Хоёрдугаар эмнэлгээс над дээр ирсэн байна. Мянгадаас ирж байсан байна. Ингээд мэдээллүүд.

Энэ болохоор миний явуулсан мэдээлэл. Одоо үүнийг би дөнгөж сая явуулсан. Энэ мэдээллийг Мянгад сум руу. Өөрөөр хэлбэл энэ. Энэ мэдээллийг сая явуулсан. Ямар ямар үйлчилгээ явуулсан байна энэ байж байна. Явуулсан үйлчилгээнүүд маань энэ байж байна.

Хэрвээ над дээр ирсэн мэдээлэл цуцлагдах юм бол энэ цуцлагдсан жагсаалт руу орж ирнэ. Энэ бол жишээ нь цуцлагдсан шалтгаантай. Явуулснаа дахиад нэг харуулчихъя. Явуулсан маань энэ байж байна. Явуулсан үйлчилгээнүүд маань энд. Шээсний ерөнхий шинжилгээг харъя. Ийм мэдээллүүд явсан байж байгаа. Энэ жоохон харагдахгүй л байх шиг байна. Ингээд харуулъя.

Энэ ингээд явуулсан мэдээлэл. Цусны дэлгэрэнгүй шинжилгээ нь иймэрхүү байдалтай. Ингээд өөрөөр хэлбэл хийчихсэн мэдээллүүд маань ингээд явж байгаа гэсэн үг.

Энэ мэдээлэл ингээд Мянгад сум руу явчихсан. Одоо би яах вэ гэхээр эмнэлгээ солих ёстой. Би өөрийгөө хоёр эмнэлэгт тохируулчихсан гэж сая хэлсэн. Одоо би Мянгад сум руу орно. Мянгад сум руу би ороод ирчихсэн. Өөрөөр хэлбэл манай систем нөгөө “үүлэн систем” учраас нэг дотроосоо. Би өөр дээрээ Мянгад сум болон “Ангирмаа” эмнэлгийн одоо энэ байгууллагаас сонгогдсон дотрын тасаг сонгогдсон. Энэ дээр нөгөө “13В”-гийн хүсэлт ирсэн байх ёстой. Энэ ороод ирсэн байна. 12 сарын 20-нд. Одоо өөрөөр хэлбэл надад “Ангирмаа” гээд өрхийн эмнэлгээс надад ороод ирсэн хүсэлт. Өөрөөр хэлбэл эрүүл мэндийн өгөгдөл солилцож байгаа.

Нөгөө миний илгээсэн сорьц илгээх гээд явуулсан. Өсгүүр, хатуу, шингэн цэр. Нэг, нэг дугаартай Саран гээд эмч ингээд явуулсан гээд ороод ирчихсэн. Үйлчилгээнүүд нь ингээд ороод ирчихсэн. Нөгөө цусны дэлгэрэнгүйг маань нөгөө тал маань ингээд харж байх жишээтэй. Энэ өөрөөр хэлбэл хүлээж авч байгаа тал гэсэн үг.

Бид нарт хоёр боломж байгаа. Нэг цуцалж болно. Өөрөөр хэлбэл ямар нэгэн шалтгаантайгаар тэр эмнэлэг хүлээн авах боломжгүй байвал цуцалж болно. Эсвэл хуваарилж болно.

Тэгэхээр үүнийг хуваарилна. Өөрөөр хэлбэл тэр хүнд цаг товлон гэсэн үг. Тэгэхээр эмчээ сонгоно. Би өөрийгөө дотрын тасгийн эмч болгоод тавьчихсан байж байгаа. Эмчээ сонгочихно. Өөрөөр хэлбэл хүлээн авах тасгаас эмч рүү хуваарилж байна гэсэн үг. Эмчид хуваарилагдсан мэдээллүүдийг ингээд харчихна. Энэ ороод ирчихсэн байж байна. Хамгийн доод талд нь. Ингээд ороод ирчихсэн. Эмч хуваарилчихсан бол энэ доор нь цаг товлох гэдэг товч идэвхжиж байгаа. Цагаа товлон. Өөрөөр хэлбэл одоо нөгөө хүнийг чинь үзье. Хүрээд ирэхээр нь үзье. Би таны шинжилгээнүүдийг харчихлаа. Одоо та хүрээд ир гэх юм бол би цаг товлон.

Одоо би юу гэдэг юм жишээ нь энэ хүнд сахар үзье гээд. Сахар үзэх гэж байгаа бол би цагаа товлон. Цагаа товлох гэж байгаа бол тэр хүн хэдний өдрийн цаг авах юм бэ гээд ингээд цагийн систем гараад ирнэ. Би жишээ нь одоо юу гэдэг юм 22-ны өдрийн 4 цагт тэр хүнд цаг авчихъя гэж байгаа юм. 4 цагт. Ингээд цаг товлонгдчихсон. Энэ хүн дээр цаг гарчихсан гэсэн үг.

Тэгэхээр одоо нөгөө цаг товлонгдсон мэдээлэл маань цаг товлосон дотор орж ирэх ёстой. Энэ 22-ны 16.00 цагт цаг товлонгдсон ороод ирж байгаа юм. Тэгэхээр одоо энэ мэдээллийг нөгөө явуулсан “Ангирмаа” эмнэлэг маань яаж мэдэх вэ гэж байгаа. Өөрөөр хэлбэл “Ангирмаа” хүнээ явуулсан. Гэхдээ “Ангирмаа” өвчтөндөө та тэдний өдөр тэдэн цагт үзүүлээрэй гэж хэлэх ёстой.

Тэгэхээр одоо цөмөөрөө “Ангирмаа” эмнэлэг рүүгээ шилжье. Буцаад. “Ангирмаа” эмнэлэг рүүгээ шилжээд нөгөө “13В”-гийн явуулсан илгээсэн хүсэлтийнхээ цонх дээр очоод цаг товлосон дээр ороод ирэхээр энэ байна. Таныг 12 сарын 22-ны өдрийн 16.00 цагт цаг товлосон. Мянгад суман дээр.

Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ өвчтөн одоо Мянгад сум руугаа өдрөө товллоод 22-ны 16.00 цагт биеэ бэлдээд очно оо гэсэн үг. Тэгэхээр энэ хооронд ингээд бүх мэдээлэл явж байгаа.

Одоо энэ дээр би сая хоёр анхан шатны эмнэлгийн хооронд үзүүллээ. Одоо би та нарт “**Метронетворкс**” компанийн **e-health** систем буюу Дундговь аймаг руу илгээж үзүүлье. Дундговь аймаг руу. Би бас өөрийгөө илгээнэ. Би бас сая хэлсэн. Хүний мэдээлэл хамаагүй явуулж болохгүй байгаа учраас би өөр дээрээ мэдээлэл үүсгэсэн байж байгаа.

Би та бүхэнд юу яая. Арай өөр байдлаар. Би энд бас Хоёрдугаар эмнэлгийн систем рүү нэг эмчийн эрхийг гуйгаад орчихсон. Эндээс би энэ хүний Хоёрдугаар эмнэлгээс Дундговь руу илгээе.

Давхар илгээхтэй зэрэгцээд энэ тасгийг нь сонгож болж байгаа. Тухайн эмнэлэг дээр нүд үү, шүд үү, дотроор явуулж байна уу ч гэдэг юм уу ингээд тасгыг нь сонгож болно. Энэ хүнийг шууд биеэр очихоор гээд тавьчихъя. Энэ хүн дээр үйлчилгээг нь явуулъя. Энэ улаанаар байгаа үйлчилгээнүүд нь бүр өмнөх өрөө систем орохоос өмнө хийгдсэн байсан учраас кодлогдоогүй. Өөрөөр хэлбэл кодлогдсон өгөгдлүүд нь ингээд байж байгаа.

Би энд албаар дүрс оношилгоотой буюу хэвлэлийн эхо-той. Сахар энэ хоёрыг илгээе. Ингээд илгээгдсэн. Одоо би та бүхэнд энэ дискээр нэг компьютероос харуулахын тулд дискээр “**Метронетворкс**” компанийн систем рүү орчихсон. Одоо энэ цонх маань дискээр орчихсон харагдаж байгаа.

Тэгэхээр Э.Халиун гээд мэргэжилтэн одоо Та бүхэнд яг харуулна. Дундговийн хэсгийг.

**Э.Халиунаа:** Сайн байна уу? Өдрийн мэнд хүргэе. “**Метронетворкс**” компанийн инженер Э.Халиун байна.

Бид хэд Дундговь аймгийн эмнэлэг рүү Эрүүл Мэндийн Үндэсний Төвөөр хандаад орчихсон байгаа. Тухайн эмнэлэг дээр илгээсэн мэдээлэл, ирсэн мэдээлэл гэсэн хоёр цонх байгаа.

Илгээсэн мэдээлэл гэдэг нь юу юм бэ гэхээр Дундговь аймгийн эмч нар одоо хүмүүсээ илгээсэн датанууд нь харагдаж байгаа гэсэн үг. Өөрөөр хэлэх юм бол Дундговь аймгаас “Ангирмаа” руу ч гэдэг юм уу, Шастины гуравдугаар эмнэлэг ч гэдэг юм уу, Ховд аймгийн эмнэлэг рүү эмч нарынх нь илгээсэн мэдээлэл нь харагдаж байгаа.

Төлөвийн хувьд мөн ялгаагүй татгалзсан, зөвшөөрсөн, идэвхтэй гэсэн төлөвүүдтэй. Энэ өөр эмнэлэг.

**Ө.Эсболд:** Энэ компьютероосоо дамжаад орчихсон юм. Эдний эмнэлэг рүү.

**Э.Халиунаа:** Тийм.

**Ө.Эсболд:** Тэгээд одоо наад гарч байгаа шинэ цонх нь эдний эмнэлгийн систем гэсэн үг.

**Э.Халиунаа:** Энэ систем нь **e-health** гээд систем байгаа. **“Цахим эрүүл мэнд-1”** төслийн хүрээнд хэрэгжсэн. Улсын 48 эмнэлэгт ашиглагдаж байгаа систем байгаа.

Хоёрдугаар шатлал, гуравдугаар шатлал, дүүрэг, аймгийн нэгдсэн эмнэлгүүд ашиглаж байгаа. Бүх эмнэлгүүд яг энэ цонхоор яг энэ мэдээллийг **“13В”**-гээ эмнэлэг хоорондоо илгээж байгаа гэсэн үг.

Ирсэн мэдээлэл дээр нь тухайн эмнэлэг рүү явуулсан датанууд харагдаж байгаа. Одоо Хоёрдугаар эмнэлгээс Дундговь руу сая нэг хүний мэдээлэл явуулсан. Тэр мэдээллээ харъя. Хэдүүлээ. Ирсэн гээд энэ дээр сэргээх дарангуут энд огнооны хувьд ирсэн датанууд нь ингээд ороод ирж байгаа гэсэн үг.

Энэ дээр улсын Хоёрдугаар төв эмнэлгээс Тулгын Асралт гэдэг хүний мэдээлэл нь ирчихсэн байна. Үүнийг нь хэдүүлээ сонгоод харъя. Тулгын сая биеэр очих гэдэг асуумжаар илгээсэн бүх асуумжууд нь харагдаж байна. Лабораторийн мэдээлэл буюу нөгөө глюкозын мэдээлэл явж байна. Энэ дээр. Тэгээд хажуу талд нь дүрс оношилгооных нь мэдээлэл явж байна.

Өөрөөр хэлэх юм бол энэ хүний хэвлийн эхо дүгнэлт нь, тэгээд зургууд нь ингээд Дундговь аймгийн нэгдсэн эмнэлэг дээрээ хүрээд ирж байгаа гэсэн үг.

Эмч маань энэ дээр яах вэ гэхээрээ бас хоёр сонголттой байгаа. Энэ хүн эмнэлэг хоорондоо мэдээлэл нь хүрээд ирлээ. Эмчид бас хоёр сонголт байгаа. Энэ хүнийг хүлээж аваад цаг товлоод үзэх юм уу, эсвэл татгалзах юм уу гэдэг хоёр сонголттой. Татгалзсан байх юм бол шалтгаанаа бичээд татгалзаад нөгөө эмнэлэг дээрээ хүрээд ирнэ. Цаг товлох юм бол ингээд өөрийнхөө цахим систем дээрээ шууд цагаа захиалчихна гэсэн үг.

Энэ хүнийг би Дундговь аймгийн нэгдсэн эмнэлэг дээр өнөөдөр дотрын тасагт нь энэ эмч дээр нь цаг өгөөд хадгалчихъя. **“13Б”** маягтаар ирсэн. Тэгээд зөвшөөрчихье. Энэ хүн дээр би өнөөдөр дотрын тасгийн 2022 оны 12 сарын 20-ны 09.00 цагийн цаг өгчихсөн байгаа.



Хэдүүлээ одоо үүнийгээ хадгалаад л ингээд болсон гэсэн үг. Одоо тэгээд нөгөө Хоёрдугаар төв эмнэлэгт маань тухайн хүний мэдээлэл маань бас яаж харагдсан бэ. Та хэд харж болно.

**Ө.Эсболд:** Одоо Дундговь аймаг дээр бид сая цагийг нь товлоод харуулчихлаа.

Тэгэхээр одоо буцаад Хоёрдугаар эмнэлэг дээрээ ороод цөмөөрөө цаг товлосон бол ямар цаг товлосон, хэзээ үзүүлэх болчхов оо, энэ хүн гэдгээ харна.

Энэ ингэж байна. 21-ний 09.00 цагт. 12 сарын 21-ний 09.00 цагт цаг товлосон. Энэ хүн өөрөөр хэлбэл Дундговьд биеэрээ очиж үзүүлэхээр ингээд цаг товлосон гэсэн үг.

Энд гарч байгаа Т.Асралт гээд хүн манай программист байгаа. Би бас өөрийнхөө мэдээллийг явуулсан. Энэ дандаа бид өөрсдийнхөө зөвшөөрлийн дагуу мэдээллийг явуулж байгаа шүү. Бас энэ зураг дарж байгаа хүмүүс хамаагүй битгий эрүүл мэндийн өгөгдлийн зураг дараарай гэж гуймаар байгаа юм.

Одоо би та бүхэнд дараагийн нэг чухал юмаа үзүүлье.

Энэ “өвчтөний портал” буюу e-card, “цахим карт” гээд систем орчихсон. Одоогоор 57 мянган хэрэглэгчтэй болчихсон явж байгаа. Үүнийг бид эрүүл мэндийн эрт илрүүлэг дээр ашиглаж эхэлсэн. Эрт илрүүлэг дээр ашиглахдаа бид эмч нарын цагийг хэмнэх үүднээс асуумжууд шууд өөр дээр нь асуухаар ерөнхийдөө зохицуулж хийсэн. Өөрөөр хэлбэл эрт илрүүлэг бол ингээд асуумжаа шууд өөрөө бөглөж болохоор ингээд хийсэн. Мөн дүгнэлтээ эндээсээ харж болохоор. Миний хувьд ороогүй.

“Цахим карт” дээр өөрөөр хэлбэл таны эрүүл мэндийн өгөгдөл солилцооны платформд холбогдсон л бол бүх мэдээлэл ингээд ороод ирж байгаа. Одоо жишээ нь энэ миний үзүүлж байсан бүх лабораторийн шинжилгээнүүд. Энэ миний эрүүл мэндийн түүхүүд. Энэ ингээд миний бүх эрүүл мэндийн түүхүүд. Төлбөр тооцоо гарсан бол надад энэ төлбөр тооцооны мэдээлэл бас орж ирж байгаа.

Ингээд хэвтэн эмчлүүлж байсан түүх байвал хэвтэн эмчлүүлж байсан түүх нь бас орж ирнэ. Иймэрхүү байдлаар. Дээр нь өвчний оношууд, эмийн мэдээлэл, ерөнхий мэдээлэл, шинж тэмдэг, цусны бүлэг, мэдээгүйжүүлэг гээд нийт бүх мэдээлэл орж ирнэ.

Дээр нь иргэн энэ цахим порталаасаа цаг захиалга хийж болж байгаа. Цаг захиалга хийж болж байгаа. Өөрөөр хэлбэл анхан шатны эмнэлгүүд буюу лавлагаа шатлалын эмнэлгүүд рүү цаг захиалгаа хийж байгаа. Ингээд эндээсээ эмнэлгээ сонгоно. Энд системд холбогдсон бүх эмнэлэг ингээд ороод ирчихсэн байж байгаа. Эндээсээ цаг захиалгаа хийж болно.

Мөн адилхан захиалгынхаа жагсаалтыг харж болно. Захиалгынхаа жагсаалтуудыг харж болно. Би сүүлийн нэг сараар хайгаад өөрийнхөө захиалсан захиалгуудыг ингээд харж болно.

Мэдээж хариу харах гээд янз бүрийн шинжилгээний хариу гарч ирсэн бол хариунууд нь ингээд ороод ирнэ. Жишээ нь, “Ангирмаа” дээр хийсэн түргэн тусламжийн хариу ингээд ороод ирчихсэн байх жишээтэй.

Энэ дээр бид давхар юу хийсэн гэхээр өвчний карт дээр хүүхдүүдийг нь холбож өгсөн байж байгаа. Би мөн адилхан өөрийнхөө хүүхдийг холбосон. Өөрөөр хэлбэл Эсболдын Молор гээд. Би ингээд Эсболдын Молор гээд дарчих юм бол шууд мэдээлэл солигдоод миний хүүхдийн бүх мэдээллүүд солигдож орж ирнэ гэсэн үг. Жишээ нь, одоо юу гэдэг юм манай хүүхдийн үзүүлсэн мэдээллүүд гэхэд одоо жишээ нь **“Family Medical Clinic”** эмнэлэгт өтгөний шимэгч хорхой тодорхойлох шинжилгээ өгсөн ч гэдэг юм уу.

Ингэж яагаад холбосон юм гэхээр насанд хүрээгүй хүүхдүүд өөрсдөө хандах эрхгүй учраас тухайн асран хамгаалагчийнх нь эрхээр нь буюу хүүхдүүдийг нь уяж өгсөн байгаа. Ингээд тэр хүний бүх мэдээлэл ингээд орж ирнэ.

Одоо би та бүхэнд яг бодитойгоор өөр дээрээ шилжүүлж байгаад нэг бодитой харуулъя. Өөрийнхөө мэдээлэл рүү шилжье. Би өөр дээрээ нэг шинжилгээ хийж үзүүлье. Та бүхэнд. Тэгэнгүүт шинжилгээний мэдээлэл өөрөөр хэлбэл шууд орж ирнэ гэсэн үг.

Одоо бол эмнэлгээр орчихсон байгаа юм. Тийм. Эмнэлгээр. Одоо би ингэх гэж байгаа юм. Би өөрөө эмчийн эрх тавьчихсан. Өөр дээрээ. Өөрөө эмч болчихоод байгаа юм. Би. Тэгээд би одоо эмчээр ороод. Дээр нь Ө.Эсболд гэдэг өөр дээрээ одоо би нөгөө лабораторийн шинжилгээ хийх гээд байхгүй юу. Тэгэнгүүт лабораторийн шинжилгээ шууд нөгөө өвчний портал руу хариу нь оронгуут шууд шидэх ёстой гэсэн үг.

Өвчтөний орж байгаа нь энэ. Өвчний ороод байгаа маань энэ байхгүй юу. Тийм. Энэ дээр эрүүл мэндийн мэдээллүүд нь. Одоо би жишээ нь лабораторийн мэдээллүүд ийм мэдээллүүд надад байж байгаа. Жишээ нь, энд би альбумин хийлгэж байсан. Альбумины мэдээлэл ингээд гараад ирнэ. Цусны дэлгэрэнгүй шинжилгээ. Нөгөө над дээр хийгдсэн байсан цусны дэлгэрэнгүй шинжилгээ, мэдээлэл энэ байж байгаа.

Одоо би та бүхэнд яг дахиад нэг шинэ шинжилгээ хийлгээд, тэр нь шууд орж ирж байна уу гэж харуулах гээд байгаа юм.

Яг одоогоор **“эрүүл мэндийн өгөгдөл солилцооны платформ”**-д холбогдсон эмнэлгүүд л орж ирж чадаад байгаа юм.

**С.Энхболд:** Зүгээр сая гишүүн яг өөрт чинь байсан MRI, CT-ний зураг байна уу л гэж асуугаад байна.

**Ө.Эсболд:** Надад байхгүй. Тэгээд байхгүй учраас Т.Асралт гээд нөгөө үзүүлчихсэн байсан инженерээ гуйгаад би Т.Асралтыг Хоёрдугаар эмнэлэг дээр үзүүлчихсэн байсныг нь сая ашигласан гэсэн үг.

**Ж.Чинбүрэн:** Одоо би н.Чинбүрэн гэдэг иргэн. Би одоо халдварт дээр очоод үзүүлье л дээ. Нэг эмчид. Тэр н.Болд гэдэг эмчид очоод үзүүлэхэд би Хоёрдугаар эмнэлэгт хийнэ шүү дээ. Одоо холбогдсон. Тийм ээ. Холбогдсон CT<sub>[computed tomography]</sub>-Гээ шууд факс систем рүү өгөх боломжтой юу гэж асуугаад байна.

**Ө.Эсболд:** Боломжтой. Харин тэрийг харуулах кэйс нь байхгүй болчихоод байна л даа.

Сая эхо шилжүүлж харуулаад байгаа нь тэр. Эхо шидэж өгөөд байгаа нь тэр.

**Ж.Чинбүрэн:** Эхо чинь бол. Саяын орсон тэр зураг чинь ямар форматтай юм?

**С.Энхболд:** Шууд юу байхгүй. Нөгөө linescom гарцаар холбогдсон юу байна шүү. Save хийчихдэг шүү дээ. Аппарат өөрөө. Тэгэнгүүт факс руу нь шууд нэвтрээд орчихдог юм.

**Ө.Эсболд:** Тэгж аваад байгаа юм. Тийм.

**С.Энхболд:** Нөгөө CT ч яг адилхан гэсэн.

**Ө.Эсболд:** Тийм. Өөрөөр хэлбэл нөгөө факс холбогдсон эмнэлгүүд бүгд тэгж чадаад байгаа юм. Нөгөө факс нь холбогдоогүй эмнэлгүүд жоохон түвэгтэй байгаад байгаа юм.

Ерөнхийдөө миний танилцуулга ингээд болсон. Тэгээд бид ямар ч байсан бүх мэдээллээ дамжуулдаг болчихсон, хардаг болчихсон. Одоо зүгээр “13В”-гээ ашиглаж эхлэх хугацааг журам нь гарах юм бол нэвтрүүлнэ.

Ер нь бүх системүүд дээр ингээд ороод ирчихсэн. Ашиглахад бэлэн болчихсон байж байгаа. Ийм л юм байж байгаа. Ингээд анхаарал тавьсан Та бүхэнд баярлалаа.

**Э.Батшугар:** Баярлалаа. Тэгээд саяын симуляци хийхэд тийм жишиг хүний мэдээллээр хийсэн гэж заавал хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Дурдах нь зүйтэй байх гэж.

Тэгэхээр яг бодитой, хувь хүний юм биш. Жишиг хүн гаргаад.

Одоо Дэлхийн банкны санхүүжилттэй “Цахим эрүүл мэнд” төслийн хэрэгжилтийн талаарх аудитын гүйцэтгэлийн танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх танилцуулна. Нэгдүгээр микрофоныг нээе.

**Я.Сарансүх:** Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллагын Засгийн газрын шугамаар авч ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хуульд заасан хугацаанд аудитыг хийж гүйцэтгэж байна.

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан “Цахим эрүүл мэнд” төслийн санхүүжилтийн хэлэлцээрийг 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдөр Улсын Их Хурлаар соёрхон баталсан ба төслийн хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаа 2016 оны 6 дугаар сарын 02-ноос албан ёсоор эхэлсэн байна.

Энэ төслийг Дэлхийн банкны нийт 19.5 сая америк долларын хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлж, 2022 оны 9 дүгээр сарын 30-нд хэрэгжиж дуусахаар төлөвлөсөн.

Төсөл 2021 оны жилийн эцсийн байдлаар 39.5 хувь буюу 7.7 сая америк долларын санхүүжилтийг авч, 2022 оны 9 дүгээр сарын 30-нд байгуулсан хэлэлцээрийн дагуу дуусгавар болсон байна.

Төслийн 2017-2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийсэн эрүүл мэндийн мэдээлэл солилцооны нэгдсэн платформ боловсруулах, хөгжүүлэх, туршин нэвтрүүлэх гэрээт ажлын явц хангалтгүй, төсөл зорилтот үр дүндээ хүрэхгүй, эрсдэл үүсэж, төлөвлөсөн санхүүжилтийг төсөл хэрэгжих хугацаанд зарцуулаагүй байна.

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, баталсан төсвийн хүрээнд зардал гаргах, бүртгэл тайлагналтай холбоотой зөрчлүүд илэрсэн тул хязгаарлалттай дүгнэлт өгч, холбогдох хууль тогтоомж, стандартыг мөрдөж ажиллах албан шаардлага, зөвлөмж өгсөн.

Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформыг боловсруулах, хөгжүүлэх, туршин нэвтрүүлэх 6 сая америк долларын санхүүжилттэй ажлын гэрээг Солонгос Улсын **Taihan Cable & Solution** компанитай 2021 оны 6 дугаар сард гэрээ байгуулсан байна.

Эрүүл мэндийн платформ байгуулах энэ гэрээт ажлын урьдчилгаа төлбөрийг төлсөн ч уг ажлын гүйцэтгэл Дэлхийн банкны шаардлагад нийцээгүй

байгаа тул мэдээллийн технологийн аудит оруулах саналыг Дэлхийн банкнаас гаргасан. Бусад худалдан авах ажиллагаа нь уг платформын гэрээт ажилтай холбоотой тул хойшлогдсон байна.

Ажил гүйцэтгэгч компани нь авсан санхүүжилтийн хэмжээнд ажлаа гүйцэтгээгүй. Ялангуяа тэргүүлэх үүрэгтэй хамтрагч, түншийн оролцоо илт өнгөц байгаагаас харахад анх боловсруулсан загварчлалын дагуу бүрэн үйл ажиллагаатай **ННЕР** хөгжүүлэх боломжгүй байдалтай байна. Иймд харилцан тохиролцсон анхан шатны суурь функцийг боловсруулж илгээх ажлаар тус гэрээний нөхцөлийг өөрчилж, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, одоогийн бодит нөхцөл байдал болон тус үйлчилгээний тодорхойлолтод заасан үр өгөөжийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн явц, ахицыг харгалзан гэрээний хүрээнд тус ажилд зарцуулах санхүүжилтийг хязгаарлахыг Дэлхийн банкнаас Эрүүл мэндийн яаманд зөвлөсөн байна.

Тус төслийн 2022 оны санхүүгийн тайланд аудитыг хуулийн хугацаанд гүйцэтгэж, 2023 оны 2 сард аудитын дүгнэлтийг гаргаж танилцуулахаар ажиллаж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Э.Батшугар:** Ажлын хэсгийг танилцуулъя.

С.Энхболд Эрүүл мэндийн сайд, Я.Сарансүх Монгол Улсын аудиторын орлогч, Б.Билэгдэмбэрэл Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Ц.Наранчимэг Үндэсний аудитын газрын Санхүү нийцлийн аудитын газрын дарга, Б.Буянтогтох Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Амарсанаа Цахим эрүүл мэнд төслийн зохицуулагч, Ө.Эсболд **Taihan Cable & Solution** компанийн төслийн дотоодын менежер, Э.Халиунаа Метронетворкс ХХК-ийн ахлах инженер, Д.Нарантуяа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дарга, М.Баттулга Үндэсний дата төв Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал.

Мэдээлэлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү.

Ж.Чинбүрэн гишүүнээр тасалъя. Ж.Чинбүрэн гишүүний микрофоныг нээе.

**Ж.Чинбүрэн:** Баярлалаа. Бид эрүүл мэндийн салбарын маш чухал сэдвийг энд хөндөн ярилцаж байна.

Одоо тэгээд нэлээдгүй цаг хугацаа өнгөрсөн, төслийн явц өөрөө цаашаа үргэлжлэх боломжгүй болоод гацчихсан байгаа байдлыг харахад ер нь бид үүнийг Байнгын хороогоороо маш яаралтай хэлэлцэж, цаашдаа ер нь энэ төслийн тавиланг яах вэ гэдгээ бас шийдвэрлэж, Их Хурлаас дэмжлэг үзүүлэх эсэх асуудлаа шийдэх ёстой. Энэ бол гарцаагүй чухал зүйл байна.

Нийтдээ 3.5 сая иргэдийн эрүүл мэндийн мэдээлэл, түүнийг солилцох энэ тогтолцоог сая demo-гоо танилцууллаа.

Ингээд харахад ер нь мэдээллээ солилцох боломжтой болж байгаа юм байна. Эмнэлгүүд шинжилгээг давтан хийхгүй байх, хоорондоо ялангуяа лаборатори үзүүлэлтүүдээ солилцох, иргэн өөрөө мэдээллээ харах ийм боломж байгаа гэж бас харагдлаа.

Тэгээд одоо түрүүн ярьж байна л даа. Одоо жишээлбэл энэ **FHIR** гээд байгаа. Тийм ээ. Тэр толь бичиг, стандарт, өгөгдөл солилцох. Энэ Шведийн компани хийж өгөөгүй гэж ярилаа шүү дээ.

Тэгэхээр яагаад хийгээгүй юм? Үүнтэй нь ямар хариуцлага тооцсон юм гэдэг нэг асуулт байна.

Хоёр дахь зүйл. Одоо ер нь цаашдаа яах вэ? Би С.Энхболд сайдаас. Одоо дата төв дээр hardware худалдан авалтаа хийгээд тэгээд сервер чинь хүчтэй ажиллах ёстой. Энэ ингээд ажиллах юм бол гацна гээд сая энэ компанийн хүн ярьж байна шүү дээ. Тэгэхээр энэ асуудлыг яаж шийдэх ёстой юм?

Ер нь үлдэгдэл санхүүжилтээрээ бид аягүй том худалдан авалт хийх ёстой. Энэ бол сум, өрхийн эмнэлгүүдийн компьютерын тоног төхөөрөмжүүдийг их хурдан интернэттэй, хурдан компьютертэй, дээрээс нь хурууны хээгээ уншаад ажилладаг болох энэ өгөгдлүүдээ ажиллагаанд оруулахад компьютер өөрөө бас сайн байх ёстой. Hardware. Энэ худалдан авалт одоо яах вэ?

Би бас одоо энэ Дэлхийн банкнаас томилогдсон төслийн ажилтнаас бас асуумаар байна. Одоо энэ төсөл цаашдаа яах ёстой юм бэ? Ямар гаргалгаа байна?

Бид ингээд хаяхад амархан. Цааш нь явуулахад. Нэг удаагийн гацааг нь би гаргаж өгсөн. Одоо хоёр дахь гацаагаа яах юм? Яаж шийдэх вэ? Энэ дээр өгөгдөл, гаргалгаа юу байна? Энэ тал дээр тайлбар өгөөч.

**Э.Батшугар:** 3 номерын микрофоныг нээе.

**С.Энхболд:** Ж.Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн салбарын цахим шилжилт яалт ч үгүй чухал асуудал.

Тэгэхээр Ж.Чинбүрэн гишүүний би хоёр дахь асуултад нь хариулаад, нэг дэх асуултад нь Б.Буянтогтох дарга хариулах байх. Төслийн захирал гэдгээр. Бид хатуу дэд бүтцийн худалдан авалтыг 2021 оны 7 сараас эхлэн удаа дараа Дэлхийн банканд хүсэлт тавьсан. Эд нар тодорхой нэг шалтгаанаар дандаа зогсоосон.

Энэ тавьсан слайд дээр Та бүхэн бас харж байгаа байх. 2015 оноос эхлэн бид энэ төслийн ажиллагааг нэгжийг байгуулаад энэ үйл ажиллагаа эхэлсэн.

Ж.Чинбүрэн гишүүн ажлын хэсгийг ахалж, 2021 оны 6 сард энэхүү төслийг эрчимжүүлэх чиглэлийг Засгийн газарт өгсний дагуу энэхүү ажил бас нэлээн эрчимтэй явагдсан.

2021 оны 9 сард энэ компанийн барьцаа төлбөр чөлөөлөгдөж, энэхүү гэрээ яг албан ёсоор эхэлж байгаа. Гэрээн дээрээ ч гэсэн тодорхой заачихсан. Ингээд хугацаагаараа энэхүү 2021 оны 9 сараас эхлээд гэрээ маань 2023 оны 4 сард албан ёсоор дуусах ёстой. Яамтай байгуулсан гэрээ бол яг ингэж явж байгаа.

Тэгэхээр бид бүхэн ямар ч гэсэн энэ гүйцэтгэгч компанитай бас хэд хэдэн удаа уулзалт хийсний хүчинд одоо энэ маань сая та бүхэнд энэ бодит орчинд үзүүлж байгаа программ хөгжүүлэлт маань өдий зэрэгт хүрсэн байгаа.

Бидний хувьд бид нар эхний ээлжид энэ систем угсраад дууссан. Хөгжүүлэлт хийгдчихсэн. Одоо туршилтын явцууд явагдаж байна.

Тэгэхээр бид цаашид үүнийг хатуу дэд бүтцийг яаж системээ аюулгүй, гацалтгүй, ямар нэгэн чирэгдэлгүй ажиллуулахын тулд бүх нөөц бололцоонуудыг ашигласан. Сая өнгөрсөн хугацаанд.

Дэлхийн банкнаас худалдан авалт хийгдээгүй. Бид Хоёрдугаар эмнэлэг, мөн дээрээс нь Сонгинохайрхан дүүрэгт байгаа гээд бүх нөөц хувилбаруудыг ашигласан. Үндэсний дата төв дээр байгаа ч гэсэн серверүүдийг ашигласан.

Одоо бид нар бас энэ Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар дээр ноднин худалдан авалтууд хийсэн. Бас нэлээн том сервер байгаа. Тэрийг ч бас мөн ашиглахаар ингээд зорьж байна. Ямар ч гэсэн бид энэ системээ явуулдгаараа явуулж хийх ёстой. Энэ дээр бид бүх нөөц хувилбаруудыг ашиглаж байгаа.

Мөн цаашид бид эхний ээлжинд Байнгын хороон дээр танилцуулж байгаа маань та хэдээс бас тодорхой чиглэл авахыг хүссэн учраас энэ танилцуулга, саяын энэ бодит орчинд хийсэн ажлуудаа танилцуулж байгаа юм.

Бид нар бас бусад донор байгууллагуудтай холбогдож байна. Тодорхой дэд бүтцүүд дээр дэмжлэг, хатуу дэд бүтцийг худалдан авах дээр дэмжлэг үзүүлээч гэдэг хүсэлтүүдийг тавьчихсан байгаа. Энд зарим нэг газрууд нааштай хариунууд өгч байна. Гэхдээ бид 9 сарын 30-наар эхлэн энэ санхүүжилтийг зогсоосон.

Тэгэхээр цаашид бид үүнийг Сангийн яамтайгаа ярилцана. Та хэдээс, Байнгын хороон дээрээс бас тодорхой чиглэл өгөгдөх байх гэж бодож байгаа. Мэдээж Сангийн яамтай бид энэ ажлуудаа танилцуулсны дараа бид Сангийн яам руугаа хүсэлт өгөхөөр үе шаттай явахаар төлөвлөчихсөн байгаа.

Тэр CHORUS стандарттай холбоотой асуудлыг нь.

**Э.Батшугар:** 2 номер микрофоныг нээе.

**Б.Буянтогтох:** Байнгын хорооны гишүүдийн өнөөдрийн амгаланг айлтгая. Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Буянтогтох байна. Би бас энэ төслийн захирлаар ажилладаг.

Тэгэхээр төсөл эхэлсэн цагаасаа аваад хоёр удаа сунгагдаад, гурав дахь удаагийн сунгалтыг бид Дэлхийн банканд тавьсан. Сангийн яам бас энэ дээр оролцоотой байдаг. Сангийн яам руугаа тэр төслийн удирдах хороогоо хуралдуулаад сунгах шаардлагатай байна гэдгээ тавьсан боловч одоогийн байдлаар сунгагдаагүй.

Ер нь сайд түрүүн хэллээ. Төсөл 18 сарын хугацаанд хэрэгжих ёстой байсан. Гэхдээ 18 сарын хугацаанд хэрэгжих хугацааны эхний өдөр хэзээнээс эхлэх вэ гэдэг нь тэр худалдан авагч нийлүүлэгчид урьдчилгаа төлбөрийг төлснөөр эхэлнэ гэдэг энэ нөхцөл 2021 оны 09 сарын 27-нд яг энэ шилжүүлсэн байдаг юм.

Тэгэхээр 2021 оны 09 сарын 28-наас албан ёсоор 18 сар нь эхэлж байгаа. Энэ бол гэрээ. Манай яамтай хийсэн гэрээ нь яг ийм юм.

Бидний төслийг эцсийн байдлаар хүлээж авах хугацаа 2023 оны 03 сарын 21-н. Яг **НIEP** буюу “**эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ**”-ыг авах хугацаа ирэх оны 04 сард хийгдэхээр байгаа.

Тэгээд Дэлхийн банк ч яг энэ дээр одоо хүртэл төслийг сунгахгүй гэсэн байр суурьтай байсан хэвээрээ байна. Тэгээд саяын сайдын хэлдэгээр хэрвээ дэмжлэг үзүүлбэл энэ цаашаа явах байх гэж бодож байна.

CHORUS компанийн хувьд 2 гэрээ хийгдсэн. Нэг гэрээ нь энэ эрүүл мэндийн стандарт батлах ажил байсан. Яамны зүгээс энэ стандартыг хүлээгээд авчихсан. Албан ёсоор хүлээгээд авчихсан.

Хөгжүүлэлтийн шатанд хугацаа алдсан зүйлүүд байгаа. Гэхдээ стандартыг албан ёсоор хүлээгээд авчихсан. Эцсийн барьцаа төлбөрийг бас бид нар шилжүүлэх процесс нь хийгдээд явж байгаа.

**Э.Батшугар:** Эхлээд 3 дугаар микрофоныг нээе. Дараа нь 4 дүгээр микрофоныг.

**С.Энхболд:** Жнэ төслийг 2021 оны 06 сараас эхлэн эрчимжүүлснээс хойш хоёр удаа аудит орсон байгаа.

Эхний аудит бол манайх өөрсдийн бүх оролцох байгууллагуудыг хамруулж 2022 оны 8 сард аудит орсон. Энэ дээр Цахим хөгжлийн яам болон тагнуул,



цагдаа гээд бүх цахимтай холбоотой төлөөлөх байгууллагууд оролцож аудит хийсэн.

9 сард Дэлхийн банкнаас аудит хийсэн байгаа. Бид энэ оны хавраас эхлэн олон улсын байгууллагаар аудит хийх хүсэлтийг удаа дараа тавьсан. Тендер зарласан боловч 4 компани шалгарсан. Энэ бол аудит хийх боломжгүй компаниуд байна гэдэг Дэлхийн банкнаас ийм зөвлөмж өгсөн.

Тэгээд 9 сард Латви Улсын нэг хүний бүрэлдэхүүнтэй ийм аудитыг Дэлхийн банк хийлгэсэн. Долоо хоногийн хугацаатай. Тэр хүмүүс бас тодорхой дүгнэлтүүд өгсөн. Сая Үндэсний аудитын газар бас тэр дүгнэлтийг уншиж танилцуулж байх шиг байна.

Манай улсын хийсэн аудит бас 61.3 хувьтай гэж гарсан байгаа. Тэр Дэлхийн банкнаас хийлгэсэн аудитын дүгнэлт бол 29.8 хувьтай гэж гарсан. Ийм зөрүүтэй дүгнэлтүүд гарсан байгаа.

Тэгэхээр энэ дээр тийм тодорхой ойлголтын зөрүүнүүд нэлээн гарсан. Хэсэг бүлэг хүний нөлөөлөл ч бас орсон байгаа. Үүнийг энд нуугаад хаагаад байх юм байхгүй. Мэдээж эрүүл мэндийн салбарт хийгдэж байгаа цахим төслийг хэрэгжүүлэхэд маш олон компани анхнаасаа л ер нэлээн хэл амтай явагддаг байсан. Эхний төсөл хэрэгжихэд бас нэлээн хэл ам болсон. Холбогдох хүмүүс холбогдсон. Энэ хоёр дахь төсөл дээр ч гэсэн анхнаасаа эхлэн бас нэлээн сошиалаар мэдээллүүд явагдсан. Энэ болгон дандаа ингэж улс төржүүлж, хувийн компаниудын эрх ашиг сонирхол ордог.

Тийм учраас энэ дээр бид тодорхой байр суурийг баримталж энэ төслийг нэлээн эрчимтэй, дандаа нөөц хувилбаруудыг энэ хатуу дэд бүтэц дээр ашиглаж явсан.

Тийм учраас та бүгдэд өнөөдөр харуулсан энэ дүнд хүрсэн гэдгээ хэлье.

**Э.Батшугар:** 3 номерын микрофон ахиад нээе.

**С.Энхболд:** Өнөөдрийн байдлаар нийт гарсан төлбөр 7.9 сая доллар. Нийт санхүүжүүлэх төсөв бол 19.5 сая доллар байгаа.

Энэ дараагийнх нь хүснэгтийг гаргачих. Ерөнхийдөө 2015 оноос хойш хэчнээн төгрөгийн зарцуулалт гарсан бэ гэдэг нь энэ хүснэгт дээр байгаа. Бид бүхэн 2021 онд энэ компанийн барьцаа төлбөрийг чөлөөлсөн. Энэ оны 7 сард байх аа. Тийм ээ. Урьдчилгаа 30 хувийг олгочихсон байгаа. Бусад зардал бол ерөөсөө ингээд 2016 он, 2017 он, 2018, 2019, 2020 онуудад ингээд гарсан төлбөрүүд нь задаргаа нь энэ хүснэгт дээр байна.

**Э.Батшугар:** 4 дүгээр микрофоныг нээе.

**Б.Амарсанаа:** Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. “Цахим эрүүл мэнд” төслийн нэгжийн зохицуулагч Б.Амарсанаа байна.

“Цахим эрүүл мэнд” төсөл маань сая энэ 2022 оны 09 сарын 30-наар хаагдсан байгаа. Тэгээд төсөл хаагдсан болохоор Дэлхийн банктай бас одоо энэ төслийг цааш нь сунгаж үргэлжлүүлэх үү, явуулах уу гэж зөндөө ярилцсан. Тэгээд Дэлхийн банкны зүгээс төслөө яг энэ хугацаанд нь хаая гэдэг шийдвэр гаргасан.

Төсөл хаагдсанаар одоо нийт үлдэгдэл нь 9.1 сая доллар маань татагдаж байгаа. Буцаагаад Дэлхийн банк руу татагдаж байгаа гэсэн үг.

Тэгээд одоогоор төсөл сунгагдах боломжгүй. Одоо энэ төслөө хаая гэдэг байр суурин дээр Дэлхийн банк байгаа.

**Э.Батшугар:** Ж.Чинбүрэн гишүүн тодруулъя.

**Ж.Чинбүрэн:** Б.Амарсанаа зохицуулагчаас бас тодруулж асууя.

Ер нь одоо ямар нэг байдлаар Сангийн яам, Эрүүл мэндийн яам дахин хэлэлцээр хийж ер энэ төслөө дуусгая гэдэг тийм хүсэлт тавьвал Дэлхийн банк дэмжих гэдэг юм уу, үргэлжлүүлэх ч гэдэг юм уу, эсвэл дахин энэ төслийг нээх боломж нь өөрөө техникийн хувьд, онолын хувьд боломжтой юу?

**Э.Батшугар:** 2 номерын микрофоныг нээе.

**Б.Амарсанаа:** Ж.Чинбүрэн гишүүний асуултад хариулъя.

Ер нь бид яг төслийн удирдах хороогоороо дамжуулаад хүсэлтээ Дэлхийн банканд ч өгчихсөн, Сангийн яаманд ч өгчихсэн.

Сангийн яамны зүгээс тодорхой хариу өгөхгүй байгаад байгаа юм. Сангийн яам эхлээд зөвшөөрөх. Монгол талаасаа Сангийн яам зөвшөөрөх ёстой юм билээ. Процессынхоо хувьд.

Тэгээд Төслийн удирдах хорооны дарга манай Төрийн нарийн бичгийн дарга. Төслийн удирдах хороо хуралдаад саналаа 8 сард хүргүүлчихсэн юм. Тэгсэн боловч одоо хүртэл Сангийн яамнаас ямар нэгэн байдлаар хариу өгөөгүй.

Хэрвээ Сангийн яамнаас эхлээд үүнийг дэмжиж байна гэсэн шийдвэр гарсны дараа Дэлхийн банк шийдвэрээ гаргах юм билээ. Гэхдээ сайд бас Андрей Михневтэй бас уулзсан. Тэгээд эхний нөгөө Сангийн яамны шийдвэр нь одоо хүртэл хүлээгдлийн байдалтай байгаа учраас.

Хэрвээ Сангийн яамнаас зөвшөөрөөд Байнгын хороон дээрээс бас чиглэл өгчих юм бол уг нь энэ төсөл гарцаагүй дуусгах нь маш чухал ач холбогдолтой байгаа.

**Э.Батшугар:** Ц.Идэрбат гишүүний микрофоныг нээе.

**Ц.Идэрбат:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Энэ Эрүүл мэндийн яам Дэлхийн банктэй хамтарч хэрэгжүүлж байгаа энэ “Цахим эрүүл мэнд”-ийн хөтөлбөрийн асуудал бас нэлээн ч хэл амтай, хэрүүл маргаантай ийм зүйл байдаг.

Тэгээд сая ч бас сайд ер нь ямархуу учир шалтгаан байгааг ч хэллээ. Өчигдрөөс эхлээд сошиал дээр энэ талаар яваад эхэллээ. Магадгүй Байнгын хороон дээр энэ асуудлууд яригдах учраас тийм зүйлүүд гарч байгаа болов уу ч гэж ингэж бодож байгаа юм.

Тэгээд аливаа асуудлыг бид хоёр талаас нь авч үзэх ёстой л доо. Нэгдүгээрт, тэрийг одоо юу гэдэг юм, гүтгэлэг байна гээд шууд харж болохгүй. Эсвэл яамныхны үгээр их сайн явж байгаа юм байна гэж харж болохгүй.

Тэгэхээр би бол өнөөдөр энэ хуралдаанд орж ирэхээсээ өмнө өнөөдөр хэлэлцэх гэж байгаа асуудалтай холбогдуулаад өөрийн аймгийн Эрүүл мэндийн төвийн анхан болон дунд шатны бүх л байгууллагуудтай холбогдлоо л доо. Баян-Овоо сум, Бор-Өндөр, Биндэр, аймгийн нэгдсэн эмнэлэг гээд.

Тэгээд энэ **e-hospital**, энэ **e-mongolia**, энэ эрүүл мэндийн цахим шилжилтийн үйл ажиллагаа яг танай эмнэлэг дээр хэрхэн явж байгаа вэ гэдэг дээр бүгдээс нь л асууж тодрууллаа.

Тэгээд надад хэлж байгаагаар Бор-Өндөрийн. Одоо хуучнаар сум дундын эмнэлэг байсан. Биндэр хоёр. Энэ хоёр дээр асуудлууд их аятайхан явж байгаа. Аймгийн нэгдсэн эмнэлэг ч гэсэн бас ер нь голдрилдоо ороод ер нь аятайхан болж байгаа.

Баян-Овоо сумын эрхлэгч ч гэсэн яах вэ, хүндрэлтэй юмнууд байгаа. Хурууны хээгээрээ шинжилгээгээ өгдөг, хариугаа авахдаа хурууны хээгээ уншуулдаг ч гэдэг юм уу ийм зүйлүүд байгаа. Гэхдээ энэ маань ингээд цаашаа давгүй хэрэгжээд ингээд явах бололцоотой байна гэж байна.

Би ерхийн эмнэлгээс бас асуулаа. Яг ерхийн эмнэлгийн түвшин дээр энэ цахим шилжилтийн ажил яг яаж яваад байгаа юм бэ. Та нарт хүндрэлтэй юм юу байна гээд ингээд ярихаар ер нь эхлээд компьютер дээрээ ажиллахаас авхуулаад хүндрэлүүд байсан. Одоо ингээд юм жигдэрч байгаа гээд ийм зүйлүүд ярьж байгаа юм.

Ямар хүндрэлүүд одоо ингээд үүнийг цааш нь хөгжүүлэхэд гарах гээд байна вэ гэхээр сая Ж.Чинбүрэн гишүүний асуултанд нь ч бас гарлаа л даа.

Ер нь тоног төхөөрөмжийн асуудлууд нэлээн хүндэрч байгаа юм. Одоо байгаа компьютерын сервер дээр энэ том юмыг нэвтрүүлнэ гэхэд одоохондоо болж байна. Цаашдаа дийлэхээ болино гэдэг ийм зүйлийг аймгийн нэгдсэн эмнэлгийн яг IT-гийн хүн нь одоо надад хэлж байх жишээтэй байна.

Тэгэхээр миний хувьд Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон “Цахим эрүүл мэнд”-ийн энэ хөтөлбөрийг цааш нь амжилттай хэрэгжүүлэхгүй бол өнөөдөр гүйцэтгэж байгаа компани нь 80, 90 хувьтай хийчхээд байна гэдэг. Санхүүжилт нь 30 гаруй хувьтай гарчхаад байдаг. Үүнийг ингээд зогсооно гэдэг бол одоо бас маш хүндрэлтэй асуудлууд үүсэх юм байна.

Нөгөө гүйцэтгэлийн санхүүжилтийн асуудлууд, энэ эрүүл мэндийн салбар дээр хэрэгжиж байгаа энэ том бодлогын асуудал одоо цаашаа яаж явах юм. Болилоо гэх юм уу, үүнийгээ. Мөнгө байхгүй учраас болилоо гэлтэй биш.

Ингээд цааш нь нэг юм дуусгаад авчих юм бол энэ бол маш том үсрэнгүй юм болох юм байна гэж ингэж харж байгаа юм.

Тэгээд Улаанбаатар хотод ирээд энэ улсын томоохон эмнэлгүүдээр хувийн шалтгаанаар яваад үзэхэд хашаандаа багтахгүй машин, дотор нь багтахгүй хүн л бужигнаж байна шүү дээ. Энэ ингээд цахим шилжилт энэ дээр олигтойхон хийгдчих юм бол энэ бүх зүйлүүд чинь бас нэг ядаж багасах юм уу гэж ингэж хараад байгаа юм. Тийм.

Тийм учраас энэ асуудал дээр Байнгын хороо цахим шилжилтийн асуудлыг цааш нь үргэлжлүүлэх тал дээр идэвхтэй байр суурьтай ажиллах нь зөв юм байна гэж бодож байгаа юм.

Нийгмийн бодлогын байнгын хороон дээр ч мөн энэ асуудлаа яриад, танилцуулгаа хийгээд, энэ дээрээ байр сууриа илэрхийлээд хэрэгжүүлээд дуусгах нь зүйтэй юм болов уу гэсэн бодолтой байна.

Ингээд цаашаа үргэлжилдэг байлаа гэхэд бидэнд нэг тулгамдах гээд байгаа юм бол энэ боловсон хүчний асуудал байна. Энэ чинь өөрөө яг IT-гийн нэлээдгүй мэдлэг, чадвар хэрэгтэй. Эмч нар маш их ачаалалтай ажиллаж байгаа. Хажуугаар нь үүнийгээ шивнэ гэдэг бас нэг маш хүндрэлтэй юмнууд орж ирж байгаа юм билээ. Одоо энэ 03 сарын 01-нээс нөгөө Эрүүл мэндийн даатгалын хууль хэрэгжиж эхэлснээс авхуулаад компьютер дээр ажилладаг зайлшгүй шаардлага гарч ирж байгаа.

Тэгэхээр эмч нар луугаа бас үүнийгээ нэг анхаармаар юм уу гэж бодогдоод байгаа юм.

Бас нэг дутагдах гээд байгаа юм.../минут дуусав/

**Э.Батшугар:** Ц.Идэрбат гишүүнд 1 минут.

**Ц.Идэрбат:** Тоног төхөөрөмжөө шийдээд, ер нь Эрүүл мэндийн яамнаас энэ КОВИД-ын цаг үед энэ амьсгалын аппарат, зөндөө л юмнууд нийлүүлээд байгаа. Сүүлийн үеийн рентген маш их нийлүүлэгдэж байгаа. Энэ дээр ажиллаж байгаа боловсон хүчний сургалтын асуудал дээр бид онцгой анхаармаар юм билээ. Гадаад дотоодод үүнийг сургамаар юм билээ. Зарим газруудад энэ үнэтэй тоног төхөөрөмж дээрээ ажиллах боловсон хүчний дутагдалд орж байгаа юмнууд ч бас анзаарагдаад л байдаг юм билээ.

Тэгэхээр энэ гаргаж байгаа хөрөнгө оруулалтуудыг бид үр дүнтэй болгохын тулд нэгдүгээрт үргэлжлүүлэх хэрэгтэй, тоног төхөөрөмжийг нь сайжруулаад өгөх хэрэгтэй, боловсон хүчнийх нь бодлого дээр IT-гийн салбар дээр нь анхаараад өгөх хэрэгтэй. Яг ажиллаж байгаа эмч нараа бас чадавхжуулах ажлаа хийгээд явчих юм бол энэ эрүүл мэндийн салбар дээр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтууд иргэдэд үр дүнгээ өгнө өө л гэж ингэж харж байгаа гэдгээ би хэлье гэж бодож байна.

**Э.Батшугар:** 3 номерын микрофоныг нээе.

**С.Энхболд:** Ц.Идэрбат гишүүний хэлсэн үгтэй санал нэг байна. Ялангуяа орон нутагт тэр болгон хүчин чадал өндөр компьютер дээр, энгийн суурин компьютер дээр ажиллах чадвар тэр болгон манай, ялангуяа орон нутагт ажиллаж байгаа эмч ажилчдад бас дутагдалтай байгаа нь үнэн.

Энэ дээр бид маш олон удаагийн сургалтууд хийгдсэн байгаа. Мэдээж бүх юм ингээд өргөс авсан юм шиг доороо яачихна гэж байхгүй. Мэдээж тодорхой хугацаа шаардлагатай. Мэдээж цахим шилжилт гэдэг бол бас том ажил. Үүнийг хэрэгжүүлээд ард иргэд, яг хэрэглэгч дээрээ бууна гэдэг нь бас нэлээн цаг хугацаа орно. Энэ мэтчилэн бид үе шаттай энэ ажлууд, сургалтуудаа хийгээд явж байна. Бас одоо ард иргэддээ илүү ойлгомжтой байдлаар хүргэх, видео үзүүлэн, видео хичээлүүд гэх мэтчилэн маш ажлуудыг хийж байгаа.

Сүүлийн үед хийгдэж байгаа тоног төхөөрөмжийн шинэчлэлүүд нэлээн тийм өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмжүүдийг ханган нийлүүлж байгаа. Энэ маань ялангуяа шууд энэ системтэйгээ холбогдох, ялангуяа тэр com гарцтай ийм тоног төхөөрөмжүүдийг нийлүүлж байгаа.

Ингэснээрээ бидний одоо энэ хэрэглээд байгаа HIEP систем дээр ийм цахим e-card үүсэх ийм бололцоог бүрдүүлнэ. Үүний сургалтууд ч гэсэн үе шаттай хийхээр ингээд төлөвлөгдөж байгаа.

Тэгэхээр ялангуяа бидний энэ цахим шилжилтийн санхүүжилтийг одоо яах вэ бид яамны зүгээс донор байгууллагууд, олон улсын байгууллага руу хандаж байгаа. Гэхдээ өнөөдрийн Байнгын хорооны хурал дээрээ тодорхой чиглэл өгөгдвөл бид энэ чиглэл рүү ажлуудаа төвлөрүүлээд.

Мэдээж Дэлхийн банктэй дахиж ярилцах боломж байгаа. Энэ төслийг цаашаа үргэлжлүүлэх үү гэдэг дээр нэгдсэн чиглэл өгөгдвөл бид бүхний ажилд маш том дэм болох байна.

**Э.Батшугар:** Мэдээлэлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Мэдээлэлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Ж.Чинбүрэн гишүүнээр тасалъя. Ж.Чинбүрэн гишүүний микрофоныг нь нээнэ үү.

**Ж.Чинбүрэн:** Ер нь бид аудитын дүгнэлтийг сонслоо. Сайдын өөрийнх нь танилцуулгыг сонслоо. Гүйцэтгэж байгаа компанийн үйл ажиллагаа demo, демострацийг үзлээ.

Тэгээд одоо бидэнд гол хүсэж байгаа зүйл бол иргэн эмнэлэгт хандахдаа цахимаар цагаа авч болдог, эмнэлэг хооронд шилжихдээ заавал өөрөө “13В” маягт барьж гүйж явахгүйгээр эмнэлгүүд нь хоорондоо мэдээллээ солилцож чаддаг байх.

Дараагийн чухал асуудал бол иргэн өөрийнхөө энэ смартфон буюу гар утсан дээрээ эрүүл мэндийнхээ мэдээллийг үзэж харж чаддаг. Дээрээс нь тэр мэдээллээ хэн нэгэн итгэж байгаа эмчдээ өөрийнхөө нэг удаагийн нууц кодоороо ороод мэдээллээ үзүүлэх боломжтой байх. Тэр эмч нь тэр иргэний үзүүлье гэсэн мэдээллүүдийг өндөр дүрс, юуны ялгаралтайгаар, ялангуяа дүрс оношилгооны мэдээллийг харах боломжтой байх гэсэн. Үүнийг л бид энэ хөтөлбөрөөс хүсээд байгаа шүү дээ.

Тэгээд одоо буруу хөлнөөсөө босчихсон хөтөлбөр шиг ингээд эхнээсээ авхуулаад л гацаад л, гацаад л. Тэгээд л гацахаараа Сангийн яаман дээр гацдаг. Гол асуудал бол бас та нарт асуудал байгаа. Асуудлаа үнэхээр тийм манлайлалтай, тэр төгсгөлд нь хүртэл явах асуудал дээрээ үнэхээр дутсан зүйл байна.

Хэдий тийм ч гэсэн бид энэ эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг хийхгүйгээр эрүүл мэндийн салбарын хөгжил урагшлахгүй. Энэ бол ингээд гацаад нэг хөл дээрээ нэг гуталтай хүн шиг л болчихно.

Тийм учраас бид үүнийг явуулах талаас нь дэмжихээс өөр арга байхгүй. Тэгээд бид өмнөх гацааг гаргахдаа бас хэд хэдэн ийм шийдвэр дээрээ заавар, зөвлөгөөнүүд өгч байсан. Тэр дотроо одоо энэ давхардсан ажлуудаа хуваалцах, тэдгээрийн үйлдлийн систем дээрээ тэр энэ тэрийгээ хамтрах, дээрээс нь энэ эрүүл мэндийн мэдээлэл солилцох энэ платформоо илүү нээлттэй болгож хэрэглэгчид тэр программуудаа дураараа авах сонголттой хийх боломжийг нь. Аль нэг программ давуу эрх олгохгүй байх энэ чиглэл дээрээ бүр нээлттэй хэлж зарлаж, ингээд л одоо энэ ажлыг дуусгамаар байх юм.

Одоо ингээд ажил нь, санхүүжилт нь 37-гоос 38 хувь нь хийгдсэн байдаг. Нийт хийсэн ажлыг нь Аудитын ерөнхий газар бол 60 хувьтай гэж үзээд байдаг. Дэлхийн банкны өөрийнх нь томилсон аудит нь 30 хувь гээд. Дундажлаад үзэх юм бол ер нь санхүүжилт, гүйцэтгэл энэ тэр нэлээн дөхчихсөн боломжийн юм шиг л харагдаад байгаа юм.

Тэгээд Инновац, цахим бодлогын байнгын хорооноос би Байнгын хорооны даргад хүсэлт тавимаар байна. Эрүүл мэндийн салбарын энэ цахим шилжилтийг дуусгах тал дээр хэдүүлээ дахиж энэ асуудлыг дэмжиж, энэ асуудлыг Сангийн яамтай, холбогдох байгууллагатай нь холбож гүүр болж өгч, энэ ажлыг дуусгах тал дээр нь дэмжлэг үзүүлье гэсэн ийм саналтай байна.

**Э.Батшугар:** Мэдээлэлтэй холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2021 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилт, Эрүүл мэндийн яамны цахим шилжилтийн үйл ажиллагаа, Дэлхийн банкны санхүүжилттэй “Цахим эрүүл мэнд” төслийн хэрэгжилтийн талаар холбогдох байгууллагуудын мэдээллийг сонсож дууслаа.

Одоо дараагийн асуудалдаа оръё.

***Хоёр.Нүүрсийг цахимаар арилжих бэлтгэл ажлын талаар  
холбогдох байгууллагуудын мэдээлэл  
сонсох***

Нүүрсийг цахимаар арилжих бэлтгэл ажлын талаар мэдээллийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Батнайрамдал танилцуулна. 3 дугаар микрофоныг нээе.

**О.Батнайрамдал:** Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын Засгийн газраас түрүүчийн долоо хоногт экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журмыг баталсан байгаа.

Мөн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг түрүүчийн долоо хоногт Улсын Их Хурлаар амжилттай явуулж, энэ долоо хоногт эцсийн хэлэлцүүлэг орох болов уу гэсэн хүлээлттэй байгаа.

Ер нь уул уурхайн салбарын нийт экспортын дүнгээр ер нь аваад үзэх юм бол эхний 11 сарын байдлаар Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нийтдээ 10.2 тэрбум долларын орлогыг төвлөрүүлж чадсан байгаа.

Энэ нь өөрөө Монгол Улсын нийт экспортын ойролцоогоор 93 орчим хувь, дотоодын бүтээгдэхүүний 20-иос 25 орчим хувийг манай салбар дангаараа бүрдүүлж байгаа. Үүнд, яг нүүрс, зэсийн баяжмал хамгийн том хувийг эзэлдэг байгаа.

Үүн дээр бас нэг анхаарах зүйл маань Монгол Улсын нийт уул уурхайн бүтээгдэхүүний экспортын үнийн дүнгээр аваад үзэхэд дийлэнх нь төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниар нэг ёсондоо гарч экспортлогддог байгаа юм.

Тэгэхээр Засгийн газраас 2022 оны 10 дугаар сарын 05-нд 362 дугаар тогтоол гарсан байгаа. Энэхүү тогтоолын хүрээнд Эрдэнэс Тавантолгойн нүүрсийг цаашдаа цахимаар арилжаалах шийдлийг чиглэл болгосон.

Тэгэхээр энэ слайд дээр ерөнхийдөө том зургаар нь бид тайлбарлахыг оролдсон байгаа. Жишээлбэл, Тавантолгой бүлэг орд дээр аваад үзэх юм бол “**Эрдэнэс Тавантолгой**”, “**Энержиресорс Тавантолгой**” энэ компаниуд маань, тэр дундаа яг одоо жишээлбэл “Эрдэнэс Тавантолгой” илүү ам нүүрсээ зардаг.

Мөн ам нөхцөлөөр нүүрсээ зарсны дараа уртын богинын тээвэр яваад Гашуунсухайт хилээр гараад Ганцмод дээр очиж цаашаа зарагддаг.

Тэгэхээр энэ нүүрсний цахим арилжааны журмаар уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль нэгэнтээ Улсын Их Хурал дээр явж байгаа энэ үед бид шийдэл болгож цахим арилжааны түр журмыг нэг ёсондоо баталсан.

Тэгэхээр энэ журам дээр гол тавьж байгаа зарчим бол “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьд нүүрсээ цахим журмаар арилжаалахдаа Гашуунсухайт буюу хил нөхцөлөөр арилжаална гэж нэг ёсондоо тусгасан байгаа юм.

Гашуунсухайт болон Шивээхүрэн боомт дээр сүүлийн хоёр жил шинэ сэргээлтийн бодлоготой холбоотойгоор чингэлэг тээврийн терминалыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд яг энэ КОВИД-ын нөхцөл байдалтай уялдуулаад бид ашиглалтад оруулсан байгаа.

Тэгэхээр яг чингэлэг тээврийн терминал Гашуунсухайт боомт дээр байгаа. Үүнийгээ ашиглаад Эрдэнэс Тавантолгойн нүүрсийг эхний ээлжинд түр цахим журмаараа арилжаалаа гэж энэ шийдлийг гаргаж түр журмаа батлуулсан.

Энэ нүүрсний цахим арилжааны түр журмыг бичиж байх явцад хувийн хэвшлийн, одоо жишээлбэл “Энержиресорс” өөрсдөө хэрвээ бид нүүрсний цахим арилжааны журмаар цахим арилжаа руу орчих юм бол бас өөрсдийн нүүрс яаж байгаа. Тэр дундаа Гашуунсухайт боомт дахь чингэлэг тээврийн терминалаар бас өөрсдөө гаргаж байгаа нүүрсээ энэ цахимаар арилжаалъя гэсэн саналыг тавьсан.

Тэгэхээр ер нь бид энэ журмаараа Тавантолгойн бүлэг орд дахь “Эрдэнэс Тавантолгой”, “Энержиресорс”, мөн онцгой дэглэм тогтоосон орон нутгийн Тавантолгой, энэ гурван компани маань Гашуунсухайт боомт дээрх чингэлэг



тээврийн терминалаар нүүрсээ цахимаар арилжаалах боломж нөхцөл нь үүгээрээ бүрдэж байна гэсэн үг.

Тэгэхээр энэ дээр нэг жишээ авмаар байна л даа. Жишээлбэл, Эрдэнэс Тавантолгойн сайн чанарын коксжих нүүрс ам нөхцөлөөр яг өнөөдөр дунджаар 110 орчим доллароор нэг тонн нь зарагдаж байгаа.

Тэгэхээр энэ нь Хятадын талдаа Гашуунсухайт боомтоор гараад Хятадын хилээс 7 хүрэхгүй орчим километр Ганцмод овоолго дээр ойролцоогоор 210-аас 230 доллар байна.

Тэгэхээр энэ хоёрын хоорондын зөрүү 100-аас 120 доллар. Тэгэхээр ерөөсөө л цаашдаа бид энэ нүүрсээ илүү хил нөхцөлөөр зайлшгүй зарах ёстой. Тухайн компаниуд өөрсдийн тээвэрлэлтээ хариуцаж хил дээр аваачиж цаашаагаа борлуулна.

Үүнийгээ цахим арилжааны хэлбэрээр явуулна гэж тусгасан байгаа юм. Нүүрсний цахим арилжааг яг схемээр ингээд аваад үзэх юм бол Монгол Улсын Засгийн газраас нүүрс экспортлох цахим арилжааны түр журмаа гаргачихлаа. Үүний хүрээнд цоо шинэ нэг төрийн өмчит компани байгуулаад гэхээс илүүтэйгээр одоо яг 30 жилийн түүхтэй, бас туршлагатай Монголын хөрөнгийн биржийн анхдагч арилжааны платформыг бас ашиглаад эхний ээлжид цахим арилжаагаа 01 сарын 01-нээс эхэлье гэж байгаа юм.

Үүний хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос бас энэ журмын хэрэгжилтэд хяналт тавина. Нэг талаасаа мэдээж худалдагч тал байгаа. Худалдагч талын хүрээнд яг Тавантолгой бүлэг орд дээр үйл ажиллагаагаа явуулж байгаа “Эрдэнэс Тавантолгой”. Мөн сайн дурын үндсэн дээр “Энержиресорс” болон орон нутгийн Тавантолгой анхдагч арилжааны цахим платформоор Гашуунсухайт чингэлэг тээврийн терминалаар экспортолж байгаа нүүрсээ энэ цахим арилжаагаар явуулна.

Нөгөө талаасаа худалдан авагч талаас Хятадын компаниуд, эцсийн хэрэглэгчид бүгдээрээ нээлттэй энэ цахим арилжаагаар ороод худалдан авалтаа үнэ хаялцуулах журмаар хамгийн өндөр үнэ санал болгосон нь автоматаар сонгогдох энэ платформыг түр журмын хүрээнд санал болгож байгаа.

Ингэснээрээ нэг ёсондоо ялангуяа төрийн өмчит компаниуд. Тийм ээ. Үнэлгээний комисс гээд 4 гишүүн хаалттай хаалганы цаана борлуулалтын гэрээ шийддэг биш. Энэ нь олон нийтэд нээлттэй ийм цахим арилжаагаар явагдана гэсэн зарчмыг энэ журамд тусгасан байгаа. Мөн энэ зарчим бол уул уурхайн бүтээгдэхүүний бирж дээр бас орж ирсэн байгаа.

Тэгэхээр энэ нүүрсний цахим арилжааны түр журмын хүрээнд нэг ёсондоо бид илүү энэ нүүрсний худалдаагаа, экспортын арилжаагаа цахим, ил тод, мөн

хамгийн гол нь бас хил нөхцөлийн үнээр тэр Гашуунсухайт боомтын үнээр, мөн тээвэрлэлтийн илүү оновчтой шийдэл рүү орно гэж харж байгаа юм.

Улсын Их Хурал дээр уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн анхны хэлэлцүүлэг маань түрүүчийн долоо хоногийн чуулганаар амжилттай орсон. Амжилттайгаар гарсан байгаа.

Тэгэхээр одоо яг ид Улсын Их Хурал дээр эцсийн хэлэлцүүлэгт бэлдэж байгаа.

Тэгэхээр уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хуулийн ерөөсөө гол концепц маань түрүүн тайлбарласан. Жишээлбэл, эхний 11 сарын байдлаар Монгол Улсаас 10.2 тэрбум долларын экспорт төрийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн дийлэнхээр гарч байгаа бол төрийн болон төрийн өмчийн оролцоотой, мөн орон нутгийн өмчит болон орон нутгийн чинь оролцоотой аж ахуйн нэгжүүд маань нүүрсээ, уул уурхайн бүтээгдэхүүнүүдээ. Ганцхан нүүрс биш. Тийм ээ. Уул уурхайн бүтээгдэхүүнээ энэ уул уурхайн бүтээгдэхүүний биржээр заавал арилжаална гэж энэ хуульдаа тусгасан байгаа.

Тэрхүү биржийн цахим арилжааг ямар хуулийн этгээд хийх вэ гэдэг дээр Монголын төрийн өмчийн оролцоотой компани байж болно. Үүн дотроо Монголын хөрөнгийн биржийн платформыг бас нэг ёсондоо ашиглаж болохоор нээлттэй оруулж тусгасан байгаа.

Мэдээж энэ биржээр арилжаалах арилжаа маань өөрсдөө бас тусгай зөвшөөрөлтэй. Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд байх ёстой. Мөн тусгай зөвшөөрөлтэй брокерууд дундын зуучлалыг хийнэ.

Бүтээгдэхүүний хувьд **swaps, forwards, futures, options** гэсэн 4 хэлбэрээр. Мэдээж эхний 3-аас 5 жилдээ бид илүү **spot** арилжаанууд явах болов уу гэсэн хүлээлттэй байгаа. Энэхүү уул уурхайн бүтээгдэхүүний биржээр гадаад дотоодын худалдан авагчид маань өөрсдөө бүгдээрээ нээлттэй, чөлөөтэй орж, энэхүү цахим арилжаанд оролцоод уул уурхайн бүтээгдэхүүнээ үнэ хаялцуулаад авах бүрэн боломж боломжтой гэсэн үг.

Тэгэхээр үүгээрээ бас бид дундын зуучлалаас илүүтэйгээр илүү олон мэдээж шат дамжлага дамжиж байж эцсийн хэрэглэгчдээ очиж байгаа.

Тэгэхээр ялангуяа Монгол Улсын нүүрс ихэнх нь мэдээж Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу гарч байгаа.

Тэгэхээр тэр дотроо илүү эцсийн хэрэглэгчид орж ирэх тэр боломж нөхцөлийг бас энэ уул уурхайн бүтээгдэхүүний биржээр нээж өгнө гэсэн хүлээлттэй байгаа. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн бас нэг онцлог байгаа. Ялангуяа таваарын биржүүдийн хувьд хөрөнгийн биржтэй харьцуулах юм бол. Энэ

нь өөрөө цаанаа бас томоохон дэд бүтцүүд байх ёстой. Яагаад гэхээр энэ бол биет бүтээгдэхүүнүүдийг арилжаалдаг учраас итгэмжлэгдсэн агуулах, мөн терминал, тээвэр, логистикийн төв, итгэмжлэгдсэн лаборатори гэх мэтчилэн.

Тэгэхээр энэ дэд бүтэц нь бас ингээд эко системийг бас бүрдүүлж байж цаашаагаа уул уурхайн бүтээгдэхүүн одоо яг Монгол Улсаас гарч байгаа уул уурхайн бүтээгдэхүүнүүдийг тогтсон стандартаар цаашдаа худалдаалах боломж нөхцөл нь бас нээгдэнэ гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр энэ хууль нь 6 сарын 30-наас хэрэгжих зохицуулалттайгаар одоогийн хуулийн драфтдаа тусаж өгсөн байгаа. 6 сарын 30-н болтол нэг ёсондоо Монгол Улсын Засгийн газраас гаргасан экспортын нүүрсийг цахим арилжаагаар явуулах түр журмын хүрээнд бид эхний ээлжид Тавантолгойн бүлэг ордын нүүрсээ арилжаалаад эхэлнэ гэж байгаа.

Тэгэхээр мэдээж энэ хугацаанд бид тэрнээс бас олон зүйлийг сурах байх. Тэгээд 6 сарын 30-наас илүү хууль маань хэрэгжээд уул уурхайн бүтээгдэхүүнээ биржээр арилжаалаад явуулах, явах нөхцөл нь бүрдэнэ гэж тооцоолж байгаа. Баярлалаа. Энэ хүрээд дуусаж байна.

**Э.Батшугар:** Баярлалаа. Одоо Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас нүүрсээ цахимаар арилжих бэлтгэл ажлын талаар танилцуулгыг Н.Учрал сайд хийнэ. Н.Учрал сайдын микрофоныг.

**Н.Учрал:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Өнгөрсөн хугацаанд Уул уурхайн биржийн хууль Засгийн газраас өргөн мэдүүлээд Г.Ёндон сайдын үед Их Хуралд орж ирсэн. Гэсэн хэдий ч батлагдаагүй өнөөдрийг хүрсэн.

Тэгэхээр өнөөдрийн нөхцөл байдлыг эргээд харахад хамгийн бас чухалд тооцогдож байгаа хуулийг бид батлан гаргахгүйгээр маш их хугацаа алдсан байна.

Тэгэхээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар сайд бас цаг үеэ олсон энэ хуулийг хурдан хугацаанд энэ Их Хурлаар хэлэлцүүлж батлуулах ажлыг манлайлж байгаад би бас баяртай байгаа.

Өнөөдөр уул уурхайн бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсийг дотоод, гадаадын зах зээлд арилжаалахад тодорхой хэдэн асуудлууд тулгарч байна гэж салбарын яамнаас өмнө нь хэд хэдэн хурал дээр танилцуулж байсан. Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн бодит үнэ, худалдааны нөхцөл, бүтээгдэхүүний чанарын талаарх мэдээлэл хаалттай, ил тод бус байгаагаас үр ашигтай зах зээлийн үнэлгээнд нийцсэн үнээр худалдах боломжгүй байна гэдэг ийм дүгнэлтийг салбарын яам өгч байгаа.

Нөгөө талаасаа уул уурхайн бүтээгдэхүүнийг борлуулах зохион байгуулалттай зах зээл, платформ бий болоогүйн улмаас бүтээгдэхүүний үнэ ханш дэлхийн зах зээлийн үнэ ханшаас доогуур байх нөхцөл үүссэн. Энэ асуудлуудыг үндсээр нь шийдвэрлэх, Монголын газрын хэвлий дэх баялаг, уул уурхайн бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгчид нь шууд санал болгох, борлуулах боломжийг л энэ цахим бирж олгох юм байна.

Уул уурхайн биржийн хууль батлагдсанаар энэ ил тод байдал гэдэг зүйл бодит утгаараа хэрэгжиж эхэлнэ гэж ойлгож байгаа.

Бид Их Хурлаас олон хууль үйлдвэрлэдэг. Гэсэн хэдий ч амьдрал дээр очоод хэрэгжилт нь тийм их хангалттай биш. Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль дээр тэр 68 төрлийн мэдээллийг ил тод болгохоор хуульчилсан. Мэдээлэл хариуцагч холбогдох төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллагууд мэдээллийг олон нийтэд ил тод болгох үүргийг хүлээж байгаа юм.

Гэтэл Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн хэрэгжилтийн үнэлгээг Хууль зүйн яамтай хамтарсан орон тооны бус зөвлөлөөс үнэлээд үзэхээр 48 хувь хүрэхгүй байгаа юм.

Тэгэхээр Уул уурхайн яам, энэ Ашигт малтмалын газар, холбогдох байгууллагууд энэ уул уурхайн ил тод байдлыг илүү сайжруулах зайлшгүй шаардлагатай. Өнөөдөр үүссэн байгаа нөхцөл байдал болоод иргэдийн зүгээс тавиад байгаа шаардлага бол хаалттай хаалганы цаана, хөшигний цаана авлигал хээл хахууль нүүрлээд байна. Дунд нь нэг зуучлагч гэдэг нөхөр гарч ирээд авлигал аваад байна. Тэр процедур дотор чинь хулгай нүүрлээд байна. Хүн байгаад байгаа учраас хулгай тэнд явагдаад байна л гэдэг ийм шаардлагыг тавьж байна шүү дээ. Энэ чинь эрүүл шаардлага.

Тэгэхээр бид цаашдаа “а”-г “б”-гээр сольсноороо өөрчлөлт авчрахгүй гэдэг нь дамжиггүй. Тэгэхээр хүн биш агуулгаа ярьдаг. Хүн биш технологид суурилсан шийдлүүдийг санал болгосон цагт энэ хулгайгаас бүрэн салахгүй бол цаашдаа хулгай хийх боломж өөрөө хулгайчийг төрүүлээд байгаа учраас уг үндсээр нь устгаач гэж байгаа юм.

Баялагтай эзэн байя гэх юм бол иргэд өөрөө тэр цахим бирж дээр нүүрсээ ил тод, тэр олон улсын компаниуд ч гэсэн тэр, хятадын компаниуд ч гэсэн үнээ чөлөөтэйгөөр өрсөлдүүлээд, тэгээд тэр ханцуйндаа нуугаад байгаа мөнгө төгрөг нь цүнхэндээ хийгээд дамжуулаад яваад байгаа мөнгө төгрөг, зуучлагч руу очдог мөнгө төгрөг чинь, авлига чинь нүүрснийхээ үнэ дээр нөлөөлөх ёстой. Тэгж байж нүүрсний үнэ өсөөд, тэгээд цаашлаад эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх л ёстой шүү дээ. Гэтэл бид үүнийг хийж чадаагүйгээсээ өнөөдрийг хүрсэн юм байна.

Тийм учраас энэ Уул уурхайн биржийн хууль батлагдсанаар бид нарт хэд хэдэн хүлээлт байгаа. Энэ ажлын эхлэлийг тавиад Монгол Улсын Засгийн газар 12

дугаар сарын 14-ний хуралдаанаараа экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны түр журмыг баталсан.

Тэгэхээр хуульд заавал хүлээхгүйгээр энэ түр журмын хүрээнд хөрөнгийн биржийнхэн бол энэ таваарын бирж дээрээ эхлээд нүүрсийг арилжаалж эхэлнэ гэдэг ийм мэдээлэлтэй байна. Яг хөрөнгийн биржийнхээ бэлэн платформыг ашиглаад.

Цаашлаад Уул уурхайн биржийн хууль батлагдчихвал төрийн өмчийн оролцоотой ямар нэгэн аж ахуйн нэгж, байгууллага энэ цахим арилжааг хийнэ.

Тэгэхээр энэ цахим арилжааг яагаад төрийн өмчийн оролцоотой гэж байна гэхээр хувийн хэвшил энд оролцох ёстой. Жишээ нь, манай харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарынхан технологид суурилсан олон бирж бид гаргасан. Энэ биржүүдийг та нар бэлнээр нь ашиглачихаач ээ. Төр үүнийг хийж чадахгүй байгаа бол бид нарын энэ платформыг ашиглаад ил тод болгочхооч ээ гээд ингээд хүсэж байгаа.

Тэгээд энэ шийдлүүдтэй нь танилцаад эхлэхээр яг ийм бирж бараг 10 орчим байна. Технологид суурьтай ийм биржүүд. Нэг хэсэг нөгөө виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хууль гарсны дараа бүх төрлийн виртуал хөрөнгийг цахимаар арилжаалаад ингээд платформ үүсгээд явж байсан.

Тэгээд энэ цахим бирж хувийн хэвшлийн тодорхой 10, 20 хувийн оролцоотой, төр нь 10, 20 ч юм уу. Тэгээд иргэд нь өөрөө тэр биржийнхээ хувь хувьцааг эзэмшдэг ийм л биржийг байгуулах гээд байгаа юм. Уул уурхайн биржийн хууль батлагдсанаараа иргэд хяналтаа тавина, хувийн хэвшил хяналтаа тавина, төрийн оролцоотой байна. Нэг ёсондоо байгалийн баялаг учраас.

Тэгэхээр хүн бүрийн хяналт дотор, иргэдийн хяналт доор энэ арилжаа явагдана гэсэн үг. Тэгээд мэдээлэл, технологийн салбарынхан юу гэж байгаа вэ гэхээр үүнийг **blockchain** дээр бүртгэ ээ. Blockchain бүртгэнэ гэдэг бол кодлогдсон хараат бус технологид бүртгэ гэж байгаа юм. Ингээд кодлогдсон хараат бус технологид бүртгээд эхлэхээр наадахыг чинь хэн нэгэн хүн хөнддөг, хэн нэгэн хүн өөрчилдөг ийм байдал үгүй болно шүү.

Тэгэхээр технологи талаас нь бид оролцоогоо хангаад ингээд хамтрахад чөлөөтэй гэж байгаа. Одоо бол түр журмын хүрээнд Хөрөнгийн биржийн бэлэн бэлэн платформ дээр нүүрс арилжаалаад эхэлнэ. Хууль батлагдаад эхлэхээр бэлтгэл ажлаа хангуулж байгаад Хөрөнгийн биржийн дэргэд тийм нэг цахим бирж, ийм бие даасан нэгж байгуулагдаад тэр нэгжид нь тэр хувийнх нь 20 байна уу, 10 байна уу, иргэд нь хэдэн хувь байна вэ оролцоод үүнийг Хөрөнгийн бирж өөрөө зохион байгуулах ёстой гэж бид ойлгож байгаа.

Ингээд ирэх жил төрийн өмчит уул уурхайн компаниуд нэгдсэн цахим системтэй холбогдоод баталгаатай, хяналттай нүүрсийг олборлоод, тээвэрлээд экспортолж эхлэх нь гэсэн ойлголттой байна. Их Хурал дээр.

Энэ бол мэдээж “Эрдэнэс Тавантолгой” компаниас эхлэх нь байна. Бусад хувийн хэвшлийн уурхайнууд харин үүнд бэлэн үү гэдэг асуулт байгаа учраас үүнд бусад компаниудыг оролцуулах ёстой.

Гадна зах зээл дээр худалдан авагчид, тэр дундаа энэ уурхай тэр хувийнхан нь уу, төрийнх нь үү гэдэг ойлголт байхгүй шүү дээ. Монголын нүүрс л арилжаалагдаж байна гэж байгаа учраас бид үүнийг дотооддоо өөрсдөө шийдвэрлэх шаардлагатай.

Тэгэхээр Монголын бүх нүүрсний салбарын бизнесүүд ухаалаг төхөөрөмж, цахим төхөөрөмжтэй болоод энэ нэгдсэн систем цахим бизнестэй холбогдсоноор үнэлгээ нь өсөж бүгдээрээ хамтдаа хожих хэрэгтэй. Тус тусдаа үнээр өрсөлдөөд хамтдаа хохирно. Хулгай ч зогсохгүй.

Тийм учраас нэгдэх хэрэгтэй, нийлэх хэрэгтэй. Нэгдсэн журмаар атгасан гар шиг байж, экспортын нэг цонхоор баялгаа гаргаж чадах юм бол худалдан авагч тал мэдээж тэртээ тэргүй эрэлт ихтэй учраас бидэнд л давуу тал болно. Энэ боломжийг цахим шийдэл ганц шийдэж чадна гэж эндээс дүгнэмээр байгаа юм.

Тэгээд бид нэг зүйлийг ойлгох ёстой. Энэ бол зөвхөн худалдах, нөгөө арилжаа хийгдэх процесс. Яг энэ нүүрсний хулгай хаана нүүрлэсэн бэ гэвэл борлуулалтаасаа авхуулаад нүүрлэж байгаа. Борлуулалтын гэрээ байгуулагдаад л эхэлдэг. Хэдэн компани энэ компанийг оруулаач, тэр компанийг оруулаач, миний найзын компани, тэрний ах дүүгийн компани гээд нөлөөлж эхлэхээр тэнд нөгөө нөлөө бүхий хүмүүст нөлөөлж болзошгүй тул тэнд хулгай байх магадлалтай байна.

Тэгээд хөрсөө хуулаад нүүрсээ гаргаж ирээд арилжаалаад эхлэх нь ингээд цахим бирж рүү шилжчихээр нөгөө нэг гаргаж авсан нүүрсээ хил рүү очоод тээвэрлээд ирэхээр нөгөө нүүрсний чинь жин нь лабораторитойгоо нийцдэггүй энэ тэр асуудлууд гараад байгаа байхгүй юу.

Тэгэхээр анх олборлоход хийгдсэн гэрээ, тэгээд нүүрсийг тээвэрлээд хил дээр ирсэн нүүрснийхээ тэр нөгөө чанарыг нь хангаж байгаа эсэх, тэр гаалийн шинжилгээний лабораторитой нь дүгнээд ингээд явах ёстой.

Тэгэхээр хоёр ойлголт. Энд нүүрсний бирж. Нөгөө талаасаа энэ нүүрсний худалдаа эрхлэх, борлуулах, тээвэрлэх процедурыг өөрөө автоматжуулах ажил. Энэ автоматжуулах ажлыг нь одоо ямар түвшинд явж байгаа талаар Сангийн яам н.Батбилэг захирал мэдээлэл өгөх нь зөв байх.

Ингээд борлуулалтаасаа авхуулаад хийгдсэн гэрээнүүд нь цахим систем дээр нээлттэй тавигдаад ямар нэгэн хардлага сэрдлэг байхгүй. Тэгээд гаалийн

шинжилгээний лаборатори автомат системээр холбогдохоор энэ анх борлуулах гэж байсан гэрээ чинь гаалийн лабораторитой нийцэж байна гэж гаргаж ирэх ёстой.

Эмийн чанарын түр хороо байгуулагдаад бид эмийн лабораториудаар очоод үзэхээр хувийн эмийн лабораториуд илүү нөгөө олон улсын чанарт нийцсэн MNS, олон улсын ISO энэ тэр нэвтрүүлчихсэн. Түүнтэй адилхан манай гаалийн шинжилгээний лабораторид 100 хувь бас итгэх итгэл байхгүй байвал одоо жишээ нь “МАК” компани, “Энержи Ресурс”, “Оюу Толгой” ч юм уу. Тийм ээ. “Рио Тинто” ч юм уу. Эд нар бүгдээрээ лабораторитой. Тэр нүүрснийх.

Тэгэхээр тэр өөрийн лаборатори дээрээ шинжлээд гаалийн шинжилгээний лабораторитойгоо нийцээд тэгээд борлуулалтын гэрээ нийцэж байх юм бол хэлээд шууд гаргачихдаг байгаа. Нөгөө ухаалаг хилийн боомтын нэвтрүүлэх. Ингээд эхлэхээр хэн ч тэр процедурт оролцохгүй. Хэн ч. Тэгээд технологид сууриалаад ингээд явах бололцоотой байна гэж үзэж байгаа юм.

Тэгээд энэ бүрэн автомат систем нэвтрэхээр зүгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яам бол мэдээж энэ технологи талаас нь ажиллах хэрэгтэй байгаа. Тэгээд бид нарт зүгээр тодорхой ийм ийм ажлууд дээр санал байна гэдгээ бас хэлэх нь зөв байх.

Өнгөрсөн хугацаанд ERP<sub>[enterprise resource planning]</sub> системүүдийг энэ компаниуд нэвтрүүлсэн. “Эрдэнэс Тавантолгой” компани чинь бараг 2.5 тэрбумаар ERP систем аваад дэргэдэх Зүүнбаян төмөр зам 4 саяар ERP авсан. Ийм хоёр ялгаатай систем нэвтрүүлсэн. Яг нэг ERP-г нэг нь тийм 2.5-аар зарладаг. Нөгөөдөх нь болохоор 4 сая.

Тэгээд үүнийг нь шийдэхийн тулд өнөөдөр энэ **Minegolia** гээд байгаа энэ программ хангамжийн их дэлгүүрийг нээж байгаа юм. Тэр цахим биржүүдэд маш нээлттэй. Биржүүд өөрсдийнхөө платформыг систем дээрээ тавь. Уул уурхайн яам үзэж судлаад, хөрөнгийн бирж үзэж судлаад аль нь бодитой юм гэдэг үнэлэлт дүгнэлт өгөхөөс нэг ижилхэн зүйлийг нэгийг нь тэдэн тэрбумаар, нэгийг нь тэдэн саяар гэж үнэлж ингэж болохгүй шүү дээ. Тэгээд программ хангамжийн худалдан авалт хүртэл өөрөө ийм эмх цэгцгүй болчихсон байсан байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр **Minegolia**-г яг нэвтрүүлээд эхлэхэд бүх компаниуд софтверуудыг энэ дээрээ тавиад ингээд явах бололцоо нь бүрдэж байгаа юм. Тэгээд өнөөдөр ERP-нууд нь гэхэд “Эрдэнэс Тавантолгой” өнөөдрийг хүртэл ERP систем нэвтрүүлээгүй. Зарлачихсан мөртлөө үлгэн залгаад явж байгаа шүү дээ.

Яагаад үүнийг шинийг хийгээд байгаа юм. Өнөөдөр Засгийн газрын хэмжээнд хэрэгжүүлж байгаа “**Able**” байна. Тэр дижитал оффис ч юм уу. Тийм ERP нь байгаа шүү дээ. Яах вэ, хүний хийчихсэн юмыг дахиж ингэж зарлаж, туршлагагүй олон компаниудаар хийлгэж цаг хугацаа алддаг юм.

Өнөөдөр “Цахим эрүүл мэнд” ч гэсэн худалдан авалт нь өөрөө ухаалаг биш байснаас болоод л ийм асуудал нүүрлэсэн байхгүй юу. Төр өөрөө ухаалаг худалдан авалт хийж чадахгүй байна шүү дээ. Ажлын даалгавраа зарлаж чадахгүй байна шүү дээ.

Тэгэхээр мөрөөдөхөд мөнгө төлдөггүй гэж үг байдаг. Харин төр мөрөөдөхдөө мөнгө төлж байгаа. Яагаад гэхээр татварын мөнгөнөөс бүрдсэн мөнгөөрөө худалдан авалт зарлаж байгаа учраас.

Тэгэхээр энэ болгоныг шийдэх ёстой. Тэр хувийн хэвшил энэ дээр бас манлайлж оролцоно. Системийн хувьд нэгтгэх ёстой буюу хувийн хэвшил өөрсдөө тэр ERP-гаа, нөгөө цахимжуулалтыг өөрсдөө хийгээд нэгтгэхгүй бол өнөөдөр гаалийн бүрдүүлэлтийг хийхэд тээвэрлэлтийн гэрээ хийгээд гаргахдаа excel дээр шивээд байх юм бол төр хэдийгээр автоматжисан байсан ч гэсэн хувийн хэвшилтэйгээ нийцэхэд дахиад л нөгөө нэг excel дээр шивж байгаа хүнд нь хэн нэгэн хүнд нөлөөлөх байхгүй юу.

Тэгэхээр хувийн хэвшил ч бай, төр ч бай бүх талаасаа цахимжаад, системийн хувьд интеграц хийхгүй бол хэн нэгэн хүн excel дээр шивсээр байвал энэ байдал дахиад л давтагдана гэдэг ийм ойлголт байгаа юм.

Тэгээд үүн дээр хэд хэдэн санал.

Нэгд. Нийтийн мэдээллийн системд холбож байгаа төрийн opendata болон төрийн нийтийн мэдээлэл солилцооны систем e-mongolia, Эдийн засгийн яамтай хамтарч хэрэгжүүлж байгаа e-business платформоор сонирхсон иргэн, хуулийн этгээд мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай. Үүнийг интеграц хийх ёстой.

Нүүрсний биржийн ил тод байдлыг хангахад хамгийн том боломж бол өөрөө нийтийн мэдээлэл солилцооны e-mongolia систем. Төрийн онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй холбогдож байгаа жагсаалтад энэ уул уурхайн холбоотой мэдээллүүд байгаа учраас энэ сервер, тоног төхөөрөмжүүдийг Засгийн газраас гарсан тэмдэглэлээр үүрэг өгсний дагуу Үндэсний Дата Төв дээр байршуулах ёстой. Тэгээд хувьцаагаа гаргачхаж болно.

Хоёрт. Кибер аюулгүй байдлыг хэрхэн хангах вэ. Нүүрсний худалдан авагч, нийлүүлэлтээр өрсөлдөгч улсууд кибер аюулгүй байдлын индексээр тэргүүлдэг, идэвхтэй тоглогч гэж тооцогддог болохыг анхаарах зайлшгүй шаардлагатай.

Цахим биржийн системийн кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн үү. Энэ дээр манай яам тагнуулын байгууллагатай хамтарч ажиллана. Мэдээлэл хариуцагч буюу Монголын хөрөнгийн бирж мэдээллийн аюулгүй байдлыг яаж хангах вэ. Энэ дээр манай яам мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл дээр нь ажиллана. Тэгэхгүй бол энэ эрсдэлийн үнэлгээнүүдийг нь хийлгэхгүй бол бас мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой асуудал.



Гуравт. Нүүрсний цахим биржийн платформ олон бол яаж уялдуулах вэ. Энэ бирж ашигтай ажиллаад ирвэл дахиад хувийн биржүүд бий болгох нөхцөл үүснэ. Үүнд хамтран ажиллах талаар одооноос тооцож тоглоомын дүрмээ одоо хэлэлцэх хуульдаа тусгах зайлшгүй шаардлагатай. Энэ дээр мэргэжлийн Байнгын хороо хамтарч ажиллах ёстой.

Дараа нь Сангийн яамнаас нэвтрүүлж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хяналтын системд арилжаалах нүүрсний багц.../минут дуусав/

**Э.Батшугар:** Н.Учрал сайдын микрофоныг 1 минутаар нээе.

**Н.Учрал:** Сангийн яамнаас нэвтрүүлж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хяналтын системд арилжаалах нүүрсний багц бүрийг холбож баталгаажуулснаар дахин давтагдашгүй кодтой гэрчилгээ бүхий blockchain бүртгэлд оруулснаараа үнэ цэнэ нь нэмэгдэж худалдан авагчийн сонирхлыг татна.

Иймд энэ хоёр системийн уялдааг хангах талаар хамтарч ажиллах шаардлагатай.

Мөн биржээ нүүрсээ худалдаад авчихсан худалдан авагч цаашаа яах вэ. Ер нь асуудлыг бүрэн шийдэж чанартай үйлчлэхийг зорьж ажиллах шаардлагатай. “Си” зөвшөөрөл бүхий тээвэрлэгч байгууллагуудын санал. Түүн дээр бас цахимжуулах. Энэ биржийн систем нүүрснээс гадна тээвэрлэх үйлчилгээгээ бас санал болгож болно.

Мөн эцэст нь уул уурхайн олборлогч, тээвэрлэгч, экспортлогч байгууллагууд, компаниудыг экспортын нэгдсэн системтэй холбох төлөвлөгөө боловсруулж, тавигдах шаардлагыг холбогдох журам, зөвшөөрлийн тогтолцоонд оруулж хэрэгжүүлэх ажлыг 2023 оны эхний хагаст хийх ёстой.

Тэгэхээр Засгийн газраар Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Сангийн яам, Уул уурхайн яаманд үүрэг өгсөн учраас бидний хамтын ажиллагаа маш их чухал байна.

**Э.Батшугар:** Нүүрсээ цахимаар арилжих талаар бэлтгэл ажлын талаарх дүгнэлт хийсэн Н.Учрал сайддаа баярлалаа. Одоо мэдээлэлтэй холбогдуулан хүрэлцэн ирсэн албан тушаалтан танилцуулья.

Н.Учрал Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, О.Батнайрамдал Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд, Б.Билэгдэмбэрэл Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Т.Цэрэнбадрал Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга, Б.Дөлгөөн Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга, Б.Цэвэгжав “Эрдэнэс Монгол” Нэгдсэн удирдлагын стратегийн хэлтсийн дарга, Б.Гэрлээ “Эрдэнэс Монгол”-ын Хууль зүйн албаны дарга, Д.Санчир “Эрдэнэс Тавантолгой” Хуулийн

хэлтсийн дарга, Г.Адъяа “Эрдэнэс Тавантолгой” Борлуулалт, маркетингийн хэлтсийн дарга, Б.Батбилэг Гааль татвар, санхүүгийн мэдээллийн технологийн улсын үйлдвэрийн захирал, Т.Хаш-Эрдэнэ Монголын хөрөнгийн биржийн Бизнесийн хөгжлийн газрын захирал, Г.Тэмүүжин Монголын хөрөнгийн биржийн хуульч.

Мэдээлэлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Нэрээ өгнө үү. Х.Ганхуяг гишүүнээр тасалъя. Х.Ганхуяг гишүүний микрофоныг%

**Х.Ганхуяг:** Энэ өдрийн мэндийг хүргэе.

Маргааш бид энэ нүүрстэй холбоотой нээлттэй сонголт хийнэ. Яах вэ, энэ асуудлыг нэлээн судалж үзлээ. Ер нь энэ чинь ерөөсөө нүүрсчдийн нам шахуу л байгуулагдчихсан юм байна шүү дээ. Төрийнхөн дээр ороод суучихсан. Хууль хяналтын байгууллагуудаа хармаалчихсан. Бүх шат дамжлагаас хулгай хийдэг юм байна.

Тэгээд гэрээ нь тонн тутам тэдэн доллар л гэнэ. Тэр зарж байгаа юу руу шахаа хийж байгаа бараа, бүтээгдэхүүнээс тэдэн хувийг авдаг л гэнэ. Тээврийн компаниудаас нь машин тутам “Си” зөвшөөрөлтэй төдийг авдаг л гэнэ. Энэ ерөөсөө оролцоогүй ч хүн алга. Энэ бол нэлээн л том л юм болж байна л даа.

Тэгээд яах вэ, одоо бид энэ цахим биржээ аятайхан хийж чадвал нэлээн том дэвшил болох болов уу гэж найдаж байна. Гэхдээ хэд хэдэн асуултууд байна л даа.

Нэгдүгээрт, энэ арилжаагаа хэрхэн яаж хийх гэж байгаа юм? Энэ чинь одоо нөгөө ам.доллараар хийж таарах байлгүй дээ. Тэгээд энэ чинь иргэдийн долларын арилжааг хийлгэхгүй байгаа шүү дээ. Монголбанк.

Долларынхоо хадгаламжаас доллар авч чадахгүй байгаа шүү дээ. Тэгээд энэ их хэмжээний мөнгийг Монголд оруулж ирээд байршуулаад, тэгээд арилжаа хийх гэхээр тэр гүйлгээ эд тэрээ хэрхэн яаж зохицуулах юм?

Тэгээд энэ их хэмжээний мөнгийг яах юм. Монголд хуулийн этгээд байгуулж мөнгөө оруулж ирэх юм уу? Аль эсвэл одоо тэр гадаадаас шууд гүйлгээг нь хийж болохоор зохицуулалт нь хийх юм уу гэдэг нэгдүгээр асуулт байна.

Хоёрт, энэ бүтээгдэхүүний ангилалтай холбоотой асуудал байна л даа. Энэ нүүрс чинь манайх чинь боловсруулаагүй шууд гаргаж байгаа шүү дээ. Угаагаагүй, шууд ухсан юм аа л гаргаад л явуулчихаж байгаа.

Тэгэхээр энэ бүтээгдэхүүний чанар, ангилал нь бол ингээд байнга хувьсаад байх шинж чанартай л даа. Нүүрс бол. Исэлдэнэ. Агаарт гарч ирэхэд зарим нь шатна. Тэгээд бүтээгдэхүүн чанараа хэрхэн яаж хадгалах юм, яаж ангилах юм.

Тэгээд энэ угаах үйлдвэрүүдээ ер нь барихгүй юм уу? Эсвэл одоо ингээд л сорчилж ухаад л дуусах гэж байна уу? Энэ Уул уурхайн яамны хүмүүс ирсэн байна. Тэрний хариуг авчихмаар байна.

Тэгээд энэ бусад хувийн хэвшлийн энэ нүүрсний компаниудыг чинь хараад дандаа тээвэр өөрсдийн зохицуулалт хийж байгаа байхгүй юу? Өөрсдөө ачилтыг нь хийгээд, өөрсдөө тэр хилийн цаана нь буулгаж өгч байгаа байхгүй юу.

Тийм болохоор нэг үнэ, нэг чанар, нэг ийм **supply chain**[нийлүүлэлтийн сүлжээ] яваад байгаа байхгүй юу.

Тэгээд энэ чинь ингээд сая таны танилцуулгаас харахад аман дээрээсээ 120 доллароор аваад л тэгээд хил дээр 210 доллароор зардаг л гэнэ. Дунд нь тонн тутмаас 100 доллар нь тэгээд хэний ашиг болж үлдээд байгаа юм. Энэ чинь өртөг нь ерөөсөө 8 доллар л байсан шүү дээ. Тээврийн зардал. Тонн тутам. Машинаар тээвэрлэхэд. Цалин хөлс, бүх юм ороод. Энэ чинь амаасаа 120 доллар гардаг юм бол хил дээр 128 доллар зарах юм уу, эсвэл дунд нь тэр 100 доллар нь яадаг юм, энэ компанийнх нь, эсвэл тэр авлигачид нь хуваагаад аваад чихдаг юм уу? Үүнийг тодорхой болгож өгмөөр байх юм.

Энэ чинь 210 доллароор хилийн цаана зарж байгаа бол энэ чинь энэ “Эрдэнэс Тавантолгой” гэдэг компани ч тэр 120 доллар биш одоо хэд байдаг юм 180, 190 доллар шахуу орж ирэх ёстой болчихоод байна шүү дээ. Ингээд тооцоог нь хийгээд үзэхээр. Энэ чинь 100 доллар нь сох дутчихсан байгаа байхгүй юу Тэгээд үүнийгээ энэ арилжаагаараа хэрхэн яаж зохицуулах юм бэ гээд л асуултууд байна. Энэ дээр хариу авчхаад тодруулъя.

**Э.Батшугар:** Тэгэхээр дэд сайд хариулчих уу? 3 дугаар микрофоныг нээе.

**О.Батнайрамдал:** Х.Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр түрүүн жишээн дээр байсан. Яг өнөөдөр “Эрдэнэс Тавантолгой”-н нүүрс ойролцоогоор дунджаар сайн чанарын коксжих нүүрс 110 доллароор зарагдаад, яг Ганцмод Хятадын боомт дээр 210-аас 230 доллар.

Тэгэхээр энэ дунд 110-аас 120, 130 долларын зөрүү байгаа.

Тэгэхээр “Эрдэнэс Тавантолгой”-н нүүрс амнаасаа Ганцмод хүртэл уртын болон богинын тээвэр гэсэн хоёр тээврээр явдаг. Нэг ёсондоо уртын тээврээр тээвэрлэгдээд Цагаанхадын овоолго дээр очдог.

Тэгэхээр энэ тээвэрлэлтийн зардал одоо яг байгаа үнэ нь тонн тутамд 15-аас 20 доллар хувьцаа байгаа. Харин богинын тээвэр буюу Цагаанхаднаас цаашаагаа Аятадын Ганцмод боомт руу очиж байгаа үнэ маань 60-аас 80 доллар. Энэ нь өөрөө 25 хүрэхгүй километр дотор үнэ нь нэг ёсондоо 60-аас 80 долларт хэлбэлздэг.

Ер нь Ганцмод боомт дээр байгаа үнэ өсөх тусам энэ богинын тээврийн үнэ нь ингээд дагаад өсөөд байдаг.

Тэгэхээр тийм ч учраас энэ цахим журам дээрээ ч гэсэн, ер нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хууль дээрээ ч гэсэн хил нөхцөлөөр тухайн компани уул уурхайн бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсээ зарна гэж бид бүхэн оруулж ирж байгаа юм.

Тэгэхээр нэг ёсондоо тээвэрлэлтээ тухайн компани хил хүртэл өөрсдөө хариуцах нөхцөлөөр хийх нь хамгийн оновчтой.

Нүүрсний чанарын асуудал дээр 2022 ондоо. Ер нь Монгол Улсын нүүрсний чанарын стандартыг аваад үзэх юм бол хамгийн сүүлийн стандарт бол 2014 онд батлагдсан стандарт байдаг. Энэ стандартын дагуу Монголын баяжуулсан, баяжуулаагүй нүүрс нийлээд 11 төрөлд л хуваагддаг байсан. Одоо жишээлбэл коксжих нүүрсний ганцхан чанар л байдаг. Үүнийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн дээр ажлын хэсэг гараад бүх оролцогч талуудыг нэгтгэж нэг ёсондоо Монгол Улсын нүүрсний стандартыг энэ ондоо багтааж шинэчилсэн байгаа. Шинэчилсэн стандарт MNS64/57 2022 онд 22 нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний ангилал, стандартад стандарт бол одоо 11-ээс 30 төрөл рүү шилжсэн.

Тэгэхээр Монгол Улсын нүүрсний чанарын стандарт илүү олон улсын чанар луу, тэр дундаа бидний экспорт руу гаргаж байгаа Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нүүрсний чанарын стандарттай ер нь нийцэж очсон байгаа.

Тэгэхээр Монгол Улсаас гарч байгаа нүүрс захиалгаа өгөхдөө ч гэсэн битүү бирж дээр арилжаалагдахдаа ч гэсэн яг энэ стандартынхаа дагуу зарлагдана гэсэн үг.

Арилжаатай холбоотой асуудлыг Б.Дөлгөөн дарга.

**Э.Батшугар:** Эхлээд 4 номерын микрофон нэе.

**Б.Дөлгөөн:** Х.Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

**Э.Батшугар:** Өөрийгөө ахиад танилцуул даа.

**Б.Дөлгөөн:** Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн Х.Ганхуяг гишүүний асуулт хариулъя.

Цахим биржийн арилжаа явагдсанаар мэдээж нүүрсний арилжаа гаднын хөрөнгө оруулагч нар, гаднын худалдан авагч нарт илүү явагдана. Энэ тохиолдолд мэдээж гадаад валютаар илэрхийлсэн үнийн худалдан авалтууд ерөнхийдөө явагдах ёстой байгаа.

Үүнийг бид бүгдийн тооцооллоор төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасны дагуу Монголбанкны зөвшөөрөлтэйгөөр эрхэлж болох үйл ажиллагаанд хамаарч байгаа. Монголбанкнаас зөвшөөрсөн тохиолдолд энэ ажиллагааг хийгдэж болно гэж үзэж байгаа.

Арилжааны яг нөхцөлийн тухайд мэдээж худалдагч тал арилжааны зарыг ажлын 5 өдрөөс өмнө арилжаа эрхлэх зарыг тавьсан байх ёстой болж байгаа. Арилжаа эхлэхээс өмнө.

Түүнээс гадна дэнчинг худалдан авагч нар байршуулж байгаа. Ингэхдээ арилжаа эхлэхээс 30 минутын өмнө дэнчинг арилжаа эрхлэх байгууллагын Монголын арилжааны банкны дансанд байршуулахаар зохицуулсан байгаа. Ингэж арилжаанд оролцоод хэрвээ гэрээ амжилттай, хэлцэл амжилттай боллоо гэж үзэх юм бол шалгарсан хүнтэй ажлын долоо хоногийн дотор экспортын гэрээг байгуулна. Экспортын гэрээний загварыг Монголын хөрөнгийн бирж арилжаа зохион байгуулагчийн зүгээс баталж гаргаж байгаа.

Тэгэхээр энэ долоо хоногийн дотор гэрээ байгуулаад яг төлбөр тооцоог ажлын 5 өдрийн дотор яг худалдагч талын дансанд шилжүүлэх ёстой байгаа. Худалдагч тал буюу “Эрдэнэс Тавантолгой” болон бусад компаниудын арилжааны банкна дахь дансанд байршуулна. Дэнчинг мөн адил арилжаа зохион байгуулагч маань 5 өдрийн дотор тухайн худалдагч талын дансанд байршуулахаар ийм зохицуулалттай явж байгаа.

**Э.Батшугар:** 1 номерын микрофоныг.

**Т.Хаш-Эрдэнэ:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Монголын хөрөнгийн биржийн Бизнес хөгжлийн газрын захирал Т.Хаш-Эрдэнэ Х.Ганхуяг гишүүний асуултад нэмж хариулья.

Арилжааг зохион байгуулах явцын талаар мэдээлэл өгөхөд цахим арилжааг нээлттэй, ил тод, мөн оролцогчдын эрхийг бас тэгш байдлаар хангаж зохион байгуулах, мөн зах зээлийн бодит үнийг тогтоох арилжаанд нүүрсний үнэ, мөн гэрээний мэдээллийг арилжаанд оролцогчдод олон нийтэд тогтмол хүргэж ажиллана.

Арилжааны хэлцлийн үр дүнд үүссэн төлбөр тооцооны үүргийг тодорхой бүртгэх, мөн экспортын гэрээг байгуулах төлбөр тооцооны найдвартай гүйцэтгэлийг хангаж ажиллахаар бид бэлтгэл ажлаа хангаад ажиллаж байна.

Төлбөр тооцооны хувьд сая Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөний хэлсэнчлэн бид Төв банк, Монголбанкнаас зөвшөөрч байгаа гадаад валютын gateway үйлчилгээг Монголын хөрөнгийн бирж дээр

Монголын хөрөнгийн биржийн одоо ашиглаж байгаа IPO системтэй нийцүүлж бэлтгэл ажлаа бүрэн хангаж дууссан. Энэ нь өөрөө 02 сарын 01-нээс эхлээд бид хэрэгжүүлэхэд бүрэн бэлтгэл ажлаа хангаад, мөн хувийн хэвшлийн нүүрс борлуулагч байгууллага буюу “Энержи Ресурс”-тай туршилтын явцаа энэ долоо хоногт хийхээр бэлтгэл ажлаа хангаад ажиллаж байна. Мөн “Эрдэнэс Тавантолгой”-той удахгүй бид туршилтын арилжааг хийхээр бэлтгэл ажлаа бүрэн хангасан байгаа. Хөрөнгийн биржийн зүгээс бол.

**Э.Батшугар:** Х.Ганхуяг гишүүн тодруулъя.

**Х.Ганхуяг:** Энэ чинь бараг нөгөө хил нөхцөлөөр явахаар чинь энэ чинь жилийн бараг 5-аас 6-н тэрбум долларын гүйлгээ байхгүй юу.

Тэгээд та нар энэ төлбөр тооцоотой холбоотой юм аа ерөөсөө сайн нягтлаагүй байгаа байхгүй юу. Гадаадын мөнгөн дэвсгэр дээр төлбөр тооцоо хийх асуудал тэр наадах чинь зөвшөөрлийнхөө юм аа хараарай. Гадаадын хуулийн этгээд шууд авч болдог юм уу, үгүй юм уу? Уншсан юм уу тэрийгээ.

Тэгээд наад төлбөр тооцоо чинь брокерээр дамжигдаж хийнэ гэж байгаа юм. Тэгээд тийм хэмжээний санхүүгийн эрсдэлийг даах хэмжээний брокерын компани байгаа юм уу? Өдрийн наад чинь гүйлгээний дүн энэ тэр чинь асар өөр шүү дээ. Та нар одооны байгаа гүйлгээний дүнгээс чинь хэд дахин том, одооны байгаа хөрөнгийн биржийн хийж байгаа гүйлгээнээс даруй 2-оос 3 дахин том хэмжээний гүйлгээ хийгдэх гээд байгаа байхгүй юу.

Та нар яах вэ, хийж чадна гээд авах гээд л байгаа юм байна.

**Э.Батшугар:** 4 дүгээр микрофоныг нээе.

**Б.Дөлгөөн:** Х.Ганхуяг гишүүний асуултад тодруулъя.

Төлбөр тооцоог бол яг олон улсын гүйлгээтэй яг ижилхэн зарчмаар явагдана. Монгол Улсын системд нөлөө бүхий арилжааны банкны худалдагч болон арилжаа эрхлэх зохион байгуулагч байгууллагын харилцах дансанд байршуулахаар журмын төсөлд заасан байгаа. Өөрөөр хэлбэл төлбөр тооцоо одоо явагддаг арга хэмжээгээр явагдаж байгаа юм.

Түрүүн Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу бараа, ажил, үйлчилгээг гадаад валютаар илэрхийлэх, зарлаж болох зөвшөөрлийг Монголбанкнаас авахаар төлөвлөсөн. Энэ тохиолдолд ер нь төлбөр тооцоо саадгүй явагдах бүрэн боломжтой гэж үзэж байгаа.

Брокерын компанийн тухайд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль батлагдсанаар брокерын тусгай зөвшөөрөл өгөхтэй холбогдсон нөхцөл шаардлагыг тогтоох гэсэн журмууд гаргагдана. Үүнд яг.../минут дуусав/

**Э.Батшугар:** Гүйцээд хариулчихъя.

**Б.Дөлгөөн:** Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль батлагдсанаар уул уурхайн бүтээгдэхүүний биржийн зуучлагч буюу брокерын тусгай зөвшөөрлийг олгох энэ харилцаа үүсэж байгаа. Үүнд Санхүүгийн зохицуулах хорооноос тус брокерын компанид тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоох болон үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан журмуудыг гаргана.

Ингэхдээ Х.Ганхуяг гишүүний санаа зовж байгаа шиг яг үүнд нь нийцүүлж нэлээн өндөр түвшний нөхцөл шаардлагыг олон улсын жишигт байдаг нөхцөл шаардлагын дагуу л тавигдаж явна гэж харж байгаа.

**Э.Батшугар:** Би товчхон хоёр асуулт асууя.

Эхнийх нь Уул уурхайн биржийн хууль яригдаж байна. Зөв өө зөв. Гэхдээ Хөдөө аж ахуйн бирж бас үйл ажиллагаагаа явуулж байгаа. Тэгээд Хөдөө аж ахуйн бирж яг ямар платформ дээр явагдаад байгаа юм бэ? Арилжаа нь. Яах вэ уул уурхайн бирж болон нүүрс бол шууд одоо хөрөнгийн биржийн платформтой “**Millennium IT**” дээр явагдаж байгаа бол маш зөв. Энэ бол дэлхийн хамгийн том системүүд нэг. Лондонгийн хөрөнгийн бирж, Лондонгийн металлийн бирж бүгдээрээ энэ систем дээр байдаг юм. Энэ систем дээр түншлээд тэгээд нөгөө swaps, futures, option-ууд явагдаж байгаа.

Тэгэхээр тэр Хөдөө аж ахуйн биржийг ийшээ бас интеграцинд оруулах бололцоо байгаа юу гэж асууя.

Хоёрдугаар асуулт мэдээж **option** яригдахаас илүү **forward** яригдаж байна. Forward чинь болоод зах зээлийн журмаар хийгдэж байгаа л **offtake** шүү дээ. Нэг ёсны арай боловсронгуй болсон бүтээгдэхүүн.

Тэгэхээр **delivery** болон хүргэлтээ хийж чадахгүй, аль эсвэл илүү давуулж зарчихсан нөхцөлд ямар тийм хариуцлага арга хэмжээ байгаа вэ? Аль эсвэл delivery-ийг нь заавал хүргэлтийг нь хийлгэхийн төлөө ямар механизмаа яг түүнд нь нийцүүлэх вэ?

4 дүгээр микрофоныг нээе.

**Б.Дөлгөөн:** Э.Батшугар даргын асуултад хариулъя.

Энэ удаагийн цахим арилжаагаар spot арилжаа ерөнхийдөө явагдаж байгаа. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль батлагдсанаараа одоо байгаа хуулийн төслийн томъёоллоор 07 сарын 01-нээс эхэлж мөрдөгдөж эхлэхээр байгаа.

Энэ хувьд мэдээж **forward** болон бусад **derivative**-ын гэрээнүүд хэрэгжиж эхлэхээр байгаа. Энд мэдээж олон улс зайлшгүй байдаг margin болон бусад

хэлбэрээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах талаарх арга хэмжээнүүдийг нарийвчилсан журмуудаар тогтоож өгнө. Одоо яг энэ цахим арилжааны буюу одоо яг Засгийн газраас батлагдсан байгаа энэ журмын хүрээнд явагдах арилжаан дээр үүргийн гүйцэтгэл буюу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх болон бараа, бүтээгдэхүүнийг худалдагч тал маань авах асуудал үүсэж байгаа. Өөрөөр хэлбэл агуулахыг чөлөөлөх.

Үүнтэй нь холбогдуулаад бид бүхэн алдангийн зохицуулалтыг энэ журамдаа тусгачихсан байгаа. Өөрөөр хэлбэл заасан өдрөөс бараа худалдаж аваагүй байх юм бол өдөр тутам 0.1 хувийн алданги тооцогдох. Заасан хугацаанд бараагаа нийлүүлээгүй тохиолдолд худалдагч талаас бас 0.1 хувийн алдангийг нөхөж авах гэсэн ийм зохицуулалтын хүрээнд явагдаж байгаа.

Хөдөө аж ахуйн биржийн тухайд яг одоо бас мөн адил энэ цахим арилжааны платформуор дамжигдаж явагдаж байгаа. Үйлдвэржилтийн байнгын хорооноос Засгийн газарт хүргүүлсэн Байнгын хорооны тогтоол байгаа. Үүнд хөдөө аж ахуйн болон уул уурхайн бүтээгдэхүүний эрх зүйн орчныг нийлүүлж нэгдсэн биржийн чиглэл дээр хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар Засгийн газарт үүрэг өгсөн байгаа.

Тэгэхээр үүний дагуу мэдээж Засгийн газраас шаардлагатай арга хэмжээ авах байх гэж бодож байгаа.

Хорооны зүгээс үүнд бас дэмжиж ажиллаж байгаа.

**Э.Батшугар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Мэдээлэлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Х.Ганхуяг гишүүнээр тасалъя. Х.Ганхуяг гишүүний микрофоныг.

**Х.Ганхуяг:** Ер нь та нар энэ биржтэй холбоотой хуулиа батлуулахдаа энэ банктэй ярьсан уу, яриагүй юм уу. Монголбанктэй.

Одоо ингээд журмаар зохицуулна гээд байх юм. Хууль давсан журам гэж байдаггүй шүү дээ. Арилжааны банкнууд чинь хүний мөнгийг авчихаад өгдөггүй биз дээ. Тэгээд наад ийм их хэмжээний мөнгө ороод ирдэг. Тэгээд арилжааны банк нь гаргаж өгөх гэж байгаа гээд дампуураад унадаг ийм юм гарах вий дээ.

Яг энэ гүйлгээтэй холбоотой, төлбөр тооцоотой холбоотой асуудлыг та нар Монголбанктэй, банкны хууль эд нартай нь оруулах ёстой байсан байхгүй юу. Та нар худалдан авагчийн эрх ашгийг нь хамгаалсан юм хийгээгүй байна л даа. Энэ чинь иргэд мянган доллар данснаасаа авах гэж яаж үйлээ үзэж байгаа билээ. Доллар дээр нь хязгаар тавиад л энэ жилжингээ л данснаасаа доллар авч болохгүй, хоорондоо доллар шилжүүлж. Доллар хоорондоо шилжүүлж болохгүй байгаа шүү дээ. Монголд. Өөрийнх нь долларын хадгаламжаас өөрийнх нь нөгөө банканд байгаа долларын хадгалмж руу мөнгө шилжүүлж болохгүй байхад Та нар



өнөөдөр ингээд бүх юм болчихоор юм шиг. Дараа нь журмаар зохицуулна гээд байх юм.

Тэр эрхээ та нар яг хуулиар авсан юм уу? Та нар тэр эрхээ хуулиар авах ёстой шүү дээ. Хэрвээ журмаар зохицуулалтууд хийнэ гэж байвал. Яг хууль дээрээ та нар яг юу юун дээр эрх авсан юм бэ? Журмаар зохицуулалт хийх. Энэ асуудлаа хараарай. Та нар яг энэ төлбөр тооцоотой холбоотой асуудлаар ерөөсөө бэлдээгүй байна шүү. Юмаа судлаагүй байна.

Одоо хөрөнгийн бирж бол энэ хувьцаа арилжаалахдаа дандаа төгрөгөөр гүйлгээ хийдэг байхгүй юу. Тэгэхээр наадах чинь асуудалгүй. Наад гаднын хөрөнгө оруулагч чинь хэн ч байна Монголд оруулж ирээд мөнгөө солиод, тэгээд төгрөгөөр арилжаа хийдэг байхгүй юу. Та нар доллароор арилжаа хийх гээд байгаа байхгүй юу. Тэгээд нөгөө банкнууд нь мөнгийг нь аваад луу унждаг. Одоо байгаа иргэдийн мөнгийг аваад л луу унжаад сууж л байдаг биз дээ. Хэдэн банкнууд.

Тэгээд энэ талын юмнуудаа та нар ерөөсөө хараагүй байна шүү дээ. Банкны хууль судлаагүй байна. Тэгээд зөвшөөрөл авч байж арилжаанд оролцоно гэсэн юм ярьж байна. Зөвшөөрлийн хууль дээр надад тийм юм ерөөсөө санал орж ирээгүй шүү. Гадаадын аж ахуйн нэгж Монголоос доллароор гүйлгээ хийх зөвшөөрөл гэж байхгүй шүү. Юугаа ч судлаагүй шүү дээ. Та нар.

**Э.Батшугар:** Ер нь тэгээд Х.Ганхуяг гишүүний ярьж байгаа зүйл чухал шүү. Яагаад гэвэл банк хоорондын их дүнтэй гүйлгээ чинь шууд тэр доороо ордоггүй шүү дээ. Тэгээд гаднаас ороод буцаж гарч байгаа болохоор. Энэ чинь нэлээн нарийн асуудал.

Их хэмжээний гүйлгээ **RTGS**<sub>[Real Time Gross Settlement system]</sub> системээрээ явдаг. Гэх мэтчилэн зүйлүүд байгаа.

Ер нь тэгээд энэ цахимаар нүүрс арилжина. Дээрээс нь нэмээд ер нь уул уурхайн бирж гэдэг чинь бол үнэхээр чухал асуудлууд. Энэ асуудлаас болоод өнөөдөр *offtake* гэрээтэй хулгай, нүүрс хулгай гэж юм яригдаж байна.

Дахиад эдийн засагт байгаа сөрөг нөлөө нь Та бүхэн мэдэж байгаа. Үүнээс болоод манай төлбөрийн тэнцэл хасах гардаг. Тэгсэн мөртлөө худалдааны тэнцэл эерэг гараад байгаа. 2 тэрбум давчихсан байгаа. Тэгсэн мөртлөө нөгөө валют нь Монгол Улсад орж ирдэггүй. Төгрөгийн ханш сулраад байна. Энэ чинь цэвэрлэ одоо *offtake* гэрээтэй холбоотой асуудлуудын нэг илэрхийлэл дээ. Эдийн засагт шууд нөлөө өгч байгаа. Үүнээсээ болоод манай бараа, бүтээгдэхүүний үнэ өсөж байна. Импортын бараа, бүтээгдэхүүн чинь хэрэглээний 60 хувийг эзэлж байна гэх мэтчилэн асуудал байна.

Тэгээд энэ уул уурхайн бирж өөрөө үйл ажиллагаагаа цэвэр яваад эхлэхээр дараачийн асуудлууд яригдана. Жишээлбэл, том том олон улсын трейдинг хаусууд Монголд орж ирэх бололцоо нь нээгдэнэ. **GLENCORE, Noble trading**.

Noble чинь бараг гээд нүүрсний хамгийн томуудын нэг. **TRAFIGURA** гээд. Энэ чинь өөрөө бас манай Монгол Улсын эдийн засгийг тэлж өгч, ажлын байр бий болгож, гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэхэд том эерэг нөлөө болно.

Монгол Улсын бас нэг **commodity** гэхээр уул уурхай болон бусад таваарын том Дундад Азийн төв болох бүрэн бололцоотой гэж харагдаж байгаа юм. Үүнийг дамжуулаад.

Тэгээд заавал нүүрсээр дуусахгүй. Эрдэнэт, Оюу Толгойн зэсээр явах бололцоо нээгдэнэ. Тэгж байж нөгөө нэг forward гэрээ нь явагдана, бодит зах зээлийн үнээр явагдана. Энэ бүгдээрээ л эцсийн үр дүнд Монгол Улс гадаад валют орж ирж ажлын байр тэлэх, эдийн засгаа нэмэгдүүлэх, тэлэх гэх мэтчилэн асуудал яригдаж байгаа юм.

Яг үүнтэй холбоотой ахиад нэг. Би түрүүн хэлсэн чухал асуудал бол одоо нөгөө Хөдөө аж ахуйн бирж байгаа юм. Хөдөө аж ахуйн бирж бас зах зээлийн зарчмаар явах нь чухал. Яагаад би ингэж хэлж байна вэ гэхээр өнөөдрийн Монгол Улс бол нийт түүхий ноолуурын дэлхийн 40 хувийг ганцаараа нийлүүлдэг юм. 40 хувь. Энэ чинь шууд юу гэдэг юм **market maker** болох бололцоотой байхгүй юу. Монгол Улс энэ түүхий ноолуурын зах зээл дээр. Гэхдээ тэр том тоглогч, нийлүүлэгч мөртлөө өгөөж нь байхгүй, Монгол Улсын эдийн засагт. Нийт экспортын 93 хувь нь уул уурхайн бүтээгдэхүүн.

Тэгэхээр чинь эдийн засгаа солонгоруулна, экспортоо улам уул уурхайг хараат бус байлгана гэдэг бол ноолуур их чухал асуудал гэдгийг би давтаж хэлмээр байна. Ингэж байдаг малчид яг зах зээлийн үнээр ноолуураа зармаар байна. Дээрээс нь нэмээд Монгол Улс өөрөө ноолуурын брэнд болмоор байна. Кашмир, органик ноолуур гээд болох бүрэн бололцоотой.

Тэгэхээр бас дараачийн асуудал энэ ноолуурын асуудлыг л ярих нь зүйтэй гэж бодоод байна л даа. 40 хувь гэдэг чинь нэлээн тийм том тоо шүү. Нийт дэлхийн нийлүүлэлтийн.

Гишүүд үг хэлж дууслаа. Нүүрсийг цахимаар арилжих бэлтгэл ажлын талаар холбогдох байгууллагын мэдээллийг сонж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

**Бичлэгээс буулгасан:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД